

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТАНИЛЦУУЛГА	2
1.1. ОРШИЛ	2
1.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХИЙЛГЭХ ҮНДЭСЛЭЛ	2
1.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО	2
1.4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ	2
1.5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭНИЙ БАГ	3
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
2.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	4
2.2. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ	5
2.3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ	7
2.4. ҮЙЛДВЭРИЙН ХОГ ХАЯГДАЛ	7
БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ	9
БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	18
4.1. АГААРЫН ЧАНАР	18
4.2. ХӨРСӨН БҮРХЭВЧ	18
4.3. УРГАМЛАН НӨМРӨГ	19
4.4. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УС	19
БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	21
5.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	21
5.2. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	22
5.3. НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖ БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	25
5.4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ	25
5.5. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	25
5.6. ХИМИЙН БОДИС, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	26
5.7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	26
5.8. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ	31
5.8.1. Байгаль орчны төлөвлөгөөт аудитын зардал	32
5.9. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	33
5.10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ	35
БҮЛЭГ 6. ХУУЛЬ ТОГТООМЖ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

<i>Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг</i>	5
<i>Зураг 2. Ахуйн хатуу хог хаягдлын цэг</i>	7
<i>Зураг 3. Мах бэлтгэлийн цехээс гарах үйлдвэрлэлийн хатуу хог хаягдал хадгалах хөргөлттэй хэсэг</i>	8
<i>Зураг 4. Сонгинохайрхан дүүрэг орчмын агаарын чанарын индекс</i>	9
<i>Зураг 5. Судалгааны талбай орчмын агаарын чанарын индекс</i>	10

БҮЛЭГ 1. ТАНИЛЦУУЛГА

1.1. ОРШИЛ

“Хатансүйх Импэкс” ХХК нь 1996 онд байгуулагдсан. Тус үйлдвэр нь европ, монгол технологийг хослуулан эрүүл, амттай хиам, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Үйлдвэр нь үндсэн 3 чиглэлийн үйлдвэрлэл явуулдаг. Нэгдүгээрт, хиам, махан бүтээгдэхүүн, Хоёрдугаарт, Нөөшилсөн бүтээгдэхүүн, Гуравдугаарт, Ясны өтгөрүүлсэн шөл. Өнөөдрийн байдлаар 50 гаруй нэр төрлийн хиам, махан бүтээгдэхүүний технологийг эзэмшжээ. Үүнээс өдөр тутам 10 орчим нэр төрлийн бүтээгдэхүүнийг тогтмол бусад нэр төрлийг захиалгаар үйлдвэрлэж байна.

1.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХИЙЛГЭХ ҮНДЭСЛЭЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлагдах төсөл хэрэгжүүлэх, дараа дараагийн жилүүдэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухайн хуулийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр заасан.

Тус төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлыг 2023 онд “ХАТАНСҮЙХ ИМПЕКС” ХХК хийж гүйцэтгэсэн байна.

Бид бүхэн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, Монгол Улсын Засгийн газрын 2013.11.16-ны өдрийн 374 дүгээр тогтоолоор баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, БОНХС-ын 2014.04.10-ны өдрийн А-117 тоот сайдын тушаалуудыг үндэслэн боловсруулав.

1.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО

“ХАТАНСҮЙХ ИМПЕКС” ХХК -ний байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь 2023 онд хэрэгжүүлэх ажлын хүрээнд хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, нийгмийн асуудал, байгаль орчин, тухайн хороонд ажиллаж амьдрах иргэдийн харилцаа хариуцсан нэгж хэсгүүдийн хамтын ажиллагааг хангасан удирдлага зохион байгуулалтын механизмыг бүрэлдүүлж, хэрэгжүүлэхэд ашиглагдах баримт бичиг юм.

1.4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ

Энэхүү Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний аргачлал, Эрсдэлийн үнэлгээ, Эрүүл мэндийн эрсдэлийн тухай, Монгол улсын хууль тогтоомж, Байгаль орчны багц хуулиуд, Монгол улсын стандарт норм, дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэв.

Энэхүү төлөвлөгөө нь:

- Товч танилцуулга, байгаль орчны төлөв байдал, үйлдвэрийн өнөөгийн байдал
- Арьс шир боловсруулах үед үүсэх нөлөөллийн үнэлгээ
- Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад үүсэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

- Төслийн хэрэгжилтийн үед хэрэгжүүлэх арга хэмжээний зардал
- Байгаль орчин, хөдөлмөр хамгаалал аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого ба журам гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

1.5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭНИЙ БАГ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хийж, бэлтгэх ажлыг байгаль орчны зөвлөх, экспертизийн “ЭКОЛОГИЙН БҮТЭЭМЖ” ХХК төсөл хэрэгжүүлэгч “ХАТАНСҮЙХ ИМПЕКС” ХХК-тай хамтран амжилттай хийж гүйцэтгэв.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр: Хиам, махан бүтээгдэхүүний үйлдвэр

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “ХАТАНСҮЙХ ИМПЭКС” ХХК

Төслийн зорилго: Хэрэглэгчийн хүсэл ташаалд нийцсэн байгалийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дотоод, гадаадын зах зээлд Монгол малын махны үнэт чанарыг гаргасан HASU брэнд бүтээгдэхүүнээрээ танигдан урт удаан хугацаанд үйл ажиллагаагаа явуулах.

HASU брэндийн гол зорилго болсон экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд химийн орц болон гений өөрчлөлттэй нэмэлт ашиглахгүй байхад технологийн бодлогоо чиглүүлэн ажилласаар байна.

Үйл ажиллагааны чиглэл:

- Бүх төрлийн хиам, хиаман бүтээгдэхүүн
- Амталж шарсан болон утсан мах, махан бүтээгдэхүүн
- Нөөшилсөн махан /консерв/ бүтээгдэхүүн
- Боловсруулсан бэлэн хоол
- Ясны өтгөрүүлсэн шөл
- Дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн
- Амталж хатаасан мах

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн тухай мэдээлэл

Аж ахуйн нэгжийн нэр	“Хатансүйх Импэкс” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011040112
Регистрийн дугаар	2088118
Үйл ажиллагааны чиглэл	Хиам үйлдвэрлэл
Хаяг	Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 4-р хороо, 10-“Хатансүйх Импэкс” ХХК-ийн байр
Утас	70172487

Төслийн байршил:

“Хатансүйх Импэкс” ХХК-ийн “Хиам, махан бүтээгдэхүүний үйлдвэр нь Улаанбаатар хотын, Сонгинохайрхан дүүргийн 4-р хорооны нутаг дэвсгэрт Толгойт гудамж, 104/10 үйлдвэрийн бүсэд 4328 м² талбайг хамран байрлана.



Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг

2.2. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

“Хатансүйх Импэкс” ХХК нь дотоод гадаадын зах зээлд монгол нутгийн соргог бэлчээрт идээшилсэн малын махаар хийгдсэн HASU брэндийн бүтээгдэхүүнээ байгалийн цэвэр байдлаар нь хэрэглэгчдэд хүргэх зорилготой ажиллаж ирсэн.

HASU брэндийн гол зорилго болсон экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд химийн орц болон гений өөрчлөлттэй нэмэлт ашиглахгүй байхад технологийн бодлогоо чиглүүлэн баримталж байна.

Анх 2001 оноос эхлэн Япон Улсад амьтны хоолны зориулалттай адууны махан нөөшилсөн бүтээгдэхүүн, Солонгос Улсад үхрийн махан консерв экспортолж байсан ба үхэр, хонь, адууны жигнэсэн мах, үхэр хонины ясны өтгөрүүлсэн шөл зэрэг арав гаруй нэрийн HASU брэндийн бүтээгдэхүүнээ Солонгос, Иран, ОХУ-д экспортолж ирсэн түүхтэй. ОХУ, БНСВУ, БНХАУ, БНСУ-ын хорио цээр, хилийн хяналтын албадын хяналт шалгалтад орж бүтээгдэхүүн экспортлох эрх авч зөвшөөрөгдсөн. Одоо БНСУ-д сар бүр үхрийн ясны өтгөрүүлсэн шөл, БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь ямааны мах, үхрийн хатаасан борц бүтээгдэхүүнийг экспортолж байна.

Дотоодын зах зээлд 11 сүлжээ дэлгүүрийн 71 салбар дэлгүүр, 8 нэрийн 422 дэлгүүр, байгууллагын хэрэглэгч болох уул уурхайн 2 байгууллага, ресторан зоогийн газар 10, түргэн хоолны сүлжээний 26 салбарт хиам, зайдас, махан бүтээгдэхүүний хүргэлт хийж өдөрт дунджаар 1000 кг зайдас, 1500 кг хиам нөөшилсөн бүтээгдэхүүнийг түгээж байна.

Хүснэгт 2. “Хатансүйх Импэкс” ХХК-ийн үйлдвэрлэлийн хүчин чадал

№	Үндсэн түүхий эд	Үндсэн түүхий эдийн нэр	Суурилагдсан хүчин чадал			Ашиглагдаж буй хүчин чадал		
			Хоног /кг/	Сараар /кг/	Жилээр /кг/	Хоног /кг/	Сараар /кг/	Жилээр /кг/
1	Хиамны цех	Үхрийн мах	1527.27	33600.00	403200	509.09	11200.00	134400
2		Хонины мах	340.91	7500.00	90000	113.64	2500.00	30000
3		Элэг	13.64	300.00		4.55	100.00	1200
4		Гахайн мах	654.55	14400.00	172800	218.18	4800.00	57600
5		гахайн өөх	381.82	8400.00	100800	127.27	2800.00	33600

6	Консервын цех	Үхрийн мах	613.64	13500.00	162000	204.55	4500.00	54000
7		Адууны мах	204.55	4500.00	54000	68.18	1500.00	18000
8		Хонины мах	1636.36	36000.00	432000	545.45	12000.00	144000

“Хатансүйх Импэкс” ХХК нь дараах төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн борлуулж байна. Үүнд:

- ✓ Бүх төрлийн хиам, хиаман бүтээгдэхүүн
- ✓ Амталж шарсан болон утсан мах, махан бүтээгдэхүүн
- ✓ Нөөшилсөн махан /консерв/ бүтээгдэхүүн
- ✓ Боловсруулсан бэлэн хоол
- ✓ Дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүн
- ✓ Ясны өтгөрүүлсэн шөл

ТӨСЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГОРИМ, АЖИЛЛАГАА

Үйлдвэрлэлийн дамжлага нь түүхий эд туслах материал хүлээн авахаас эхлэн мах бэлтгэх, нөөшилсөн махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хиам үйлдвэрлэх хадгалах, борлуулалтад шилжүүлэх хүртэл нэг чиглэлийн урсгалтай, өөр хоорондоо огтлолцохгүй байхаар зохион байгуулагдсан. Үйлдвэрийн эрүүл ахуйг “Цэвэрлэгээ ариутгалын журам” /ХОЛАЖУ002/-аар зохицуулна. Энэ журмын хүрээнд 20 хяналтын хуудас, 6 бүртгэл бүртгэж байна.

ДОТООД ХЯНАЛТЫН ЛАБОРАТОРИЙН ТАНИЛЦУУЛГА

“Хатансүйх Импэкс” ХХК –ийн үйлдвэрийн дэргэдэх дотоод хяналтын лаборатори нь химич, микробиологич, малын эмч гэсэн бүрэлдэхүүн бүхий мэргэжилтнүүдтэй ба чиг үүргийн хүрээнд лабораторид мөрдөх дотоод журам, лабораторийн дээж авах шинжилгээ хийх журмын дагуу тогтмол хуваариар бүтээгдэхүүнд дараах шинжилгээг хийнэ.

Шинжилгээнд хэрэглэгддэг тэжээлт орчныг Монбиофарм ХХК-аас худалдан авдаг.

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТҮҮХИЙ ЭД, ТУСЛАХ МАТЕРИАЛ

Хиам, махан бүтээгдэхүүний үндсэн түүхий эд: Үйлдвэр нь хиам, консерв үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд болох мах, өөхийг гэрээт компани “Алтантариа” ХХК, “Мах Импэкс” ХХК, “Эбо Холдинг” ХХК-аас нийлүүлэн авдаг байна.

Жор орцыг Австрийн KAVO компаниас импортоор Хатансүйх Импэкс ХХК-ийн захиалгаар оруулж ирдэг.

Химийн бодисын хэрэглээ

Мах боловсруулах үйлдвэр нь Хүнсний эрдэм шинжилгээний үйлдвэрлэлийн САМО ИНСТИТУТ ХХК-тай 2019 оноос хойш хамтран ажиллаж байна. Тус үйлдвэр нь хөргөлтийн технологит аммиак ашигладаг юм.

ҮЙЛДВЭРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Үйлдвэр нь нийт 98 ажиллагчидтай, 6 алба, цех, нэгжтэй, 5 давхар барилга юм. Үүнд:

- | | |
|----------------------|------------------------------|
| ✓ Захиргаа-аж ахуй | ✓ Консервын цех |
| ✓ Лаборатори | ✓ Савлагааны цех |
| ✓ Мах бэлтгэлийн цех | ✓ Харуул, хангамжийн угаалга |
| ✓ Хиамны цех | ✓ Гал тогоо |

ҮЙЛДВЭРИЙН АЖИЛЛАХ ХҮЧИН

Хүний нөөцийн хөгжих чадамж: Тус компани нь бүтэц орон тооны хувьд нийт 94 ажилтантай байхаас 2023 оны байдлаар 98 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. Цаашид ажлын байранд ур чадвартай, түлхүүр ажилтны залгамж халааг бэлтгэх зорилгоор боловсролын судалгаа хийснээс бакалавр магистрын түвшинд дээд боловсрол эзэмшсэн 25

ажилтан нийт ажилтнуудын 43,5%-ийг, Инженер техникийн ажилтан 28 нийт ажилтнуудын 24,3%, мэргэжилтэй бөгөөд мэргэшсэн ажилтнууд 32 буюу 32,05%-ийг эзэлж байна. Ажилтнуудын тогтвортой ажиллах нөхцөл нь улирлын шинжтэй байдаг нь улсын хэмжээнд уул уурхай, барилгын ажил эрчимтэй хөгжиж байгаатай холбоотой байна. тиймээс бид цаашид үйлдвэрлэлийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх өөрийн тогтолцоотой болоход чиглэж үйл ажиллагаа явуулж байна.

2.3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ

Газар ашиглалт: Тухайн төсөл хэрэгжиж буй газар нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 4-р хорооны нутаг дэвсгэрт Эрчим хүчний гудамж, Мах Импекс ХХК-ийн хашаанд үйлдвэрийн барилга нь байрлаж байна.

Дэд бүтцийн хөгжил: Хиам, махан бүтээгдэхүүний үйлдвэр нь Улаанбаатар хотын үйлдвэрийн бүсэд байрлаж буй нь төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн асуудлыг дараах байдлаар шийдсэн байна.

Цэвэр усны хангамж: Үйлдвэр нь төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон.

2.4. ҮЙЛДВЭРИЙН ХОГ ХАЯГДАЛ

Үйлдвэрээс гарах хог хаягдлын төрөл, хэмжээ

Хиам, махан бүтээгдэхүүний үйлдвэрээс ажилчдын ахуйн хэрэглээний хог хаягдал, үйлдвэрийн мах бэлтгэлийн цехээс гарах махны, өөхний үлдэгдэл, шулсан яс зэрэг хатуу хог хаягдал болон тоног төхөөрөмжийн ариутгал цэвэрлэгээнд ашигласан бохир ус болох техникийн шингэн хаягдал гарна.

Ахуйн хатуу хог хаягдал: Үйлдвэрийн ажилчдын ахуйн хэрэглээний хатуу хог хаягдалд ахуйн хэрэглээнээс гарсан цаас, сав, баглаа боодол, ажилчдын эдэлж хэрэглэж байсан зүйлс болон ажилчдын хоолны газраас гарсан хүнсний бүтээгдэхүүний үлдэгдэл, ногооны хальс зэрэг хаягдал зүйлс гарна. Үйлдвэр нь үйлдвэрийн хашааны автозамын урд байрлах хашаанд битүүмжилсэн хогийн цэгтэй байна.

Хог хаягдлын цэгийг сайжруулан, тогтоосон хугацаанд гэрээт газраас ирж ачилт хийж байна. Энэ үйл ажиллагааг “Үйлдвэрийн хог хаягдал хаях журам” /ХОЛАЖУ003/-аар зохицуулагдаж, бүртгэл, журналыг хөтөлж байна.

Ахуйн зориулалтын хог хаягдлыг тооцоход баримталдаг зарчмаар нэг хүн өдөрт 1.5 кг хог хаягдал ялгаруулдаг гэж тооцвол үйлдвэрт нийт 98 хүн учир өдөрт 153 кг, хаягдал, сард 3970 кг, жилд 45.64 тн ахуйн хатуу хог хаягдал гарахаар тооцоо гарч байна.



Зураг 2. Ахуйн хатуу хог хаягдлын цэг

Үйлдвэрийн хатуу хог хаягдал: Мах бэлтгэлийн цехээс гарах хаягдал мах, өөхний үлдэгдэл, шулсан яс зэрэг үйлдвэрийн хатуу хог хаягдлыг Мах импекс ХХК-д нийлүүлдэг байна. Үйлдвэрлэлийн явцад гарах бусад хог хаягдлыг нойтон хуурайгаар ангилан ялгадаг.



Зураг 3. Мах бэлтгэлийн цехээс гарах үйлдвэрлэлийн хатуу хог хаягдал хадгалах хөргөлттэй хэсэг

Шингэн хаягдал

Үйлдвэрлэлийн явцад гарах шингэн хог хаягдлыг үйлдвэрийн угаалга цэвэрлэгээнд ус болон ахуй хэрэгцээнээс гарах бохир ус бүрдүүлнэ.

Бохир ус зайлуулах ажиллагаа: Үйлдвэрийн бохир ус нь бохирын шугамаар дамжин шууд төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд холбогдсон.

БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

Цаг уур


Тус үйлдвэр нь Улаанбаатар цаг уурын өртөөнөөс баруун урагш 5 км-т, Буянт-Ухаа өртөөнөөс зүүн хойш 7 км зайд далайн түвшнээс дээш 1275 м өндөрт оршино. Хэдийгээр цаг уурын өртөө нь хоногт 8 удаа хэмжилт хийхийн зэрэгцээ Дэлхийн Цаг уурын Байгууллагын тогтоосноор тухайн цаг уурын өртөөний ажиглалт нь эргэн тойрны 50 км радиус дотор хүчин төгөлдөр байх учир аль нэг өртөөний мэдээ хангалттай боловч боловч хотжилт ихтэй газар цаг уур, уур амьсгалын хэмжигдэхүүнүүд багахан зайд асар ихээр өөрчлөгддөг тул уур амьсгалын тодорхойлолтыг дээрх дээрх 2 цаг уурын өртөөний мэдээг тулгуур болгон бичлээ.

Цаг уурын Улаанбаатар өртөө хойд өргөрөгийн 47°56', зүүн уртрагийн 106°59'-т, далайн түвшнээс 1306 м өндөрт, харин Буянт-Ухаа цаг уурын өртөө хойд өргөрөгийн 47°50', зүүн уртрагийн 106°46'-т, далайн түвшнээс 1272 м өндөрт тус тус байрлана.

Судалгааг хийхдээ тус цаг уурын өртөөдийн сүүлийн 30 жилийн (1989-2018 оны) бодит ажиглалтын мэдээг цуглуулж түүнээс дундаж, хамгийн их, бага, амплитуд гэх мэтийн төрөл бүрийн математик статистикийн үзүүлэлтүүдийг тооцоолж зохих дүгнэлтүүдийг өгсөн ба тухайн үзэгдэл, хэмжигдэхүүний хугацааны өөрчлөлтийг үнэлэхдээ дээрх 30 жилийн хугацааны дундаж (1989-2018 он) болон УЦУОСМХүрээлэнгээс гаргасан уур амьсгалын нормыг (1981-2010) хооронд нь харьцуулах аргыг ашигласан.

Бүс нутгийн агаарын чанар

Бид төслийн талбай орчмын агаарын бохирдолд үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор станцуудын мэдээг ашигласан бөгөөд доор байгаа тус станцуудын үзүүлэлтээс харахад 2019 оны 03-р сарын 15-өдрийн байдлаар агаарын чанарын үзүүлэлт бага зэргийн бохирдолтой байлаа.



Зураг 4. Сонгинохайрхан дүүрэг орчмын агаарын чанарын индекс



Зураг 5. Судалгааны талбай орчмын агаарын чанарын индекс 2023/01/15-ны байдлаар =

Бидний цаашдын судалгаанд агаарын чанарын станцын мэдээллийг ашигласан бөгөөд уг станц нь төслийн талбайд илүү ойр, станцын байршлын орчмын хүн амын суурьшил, нягтшил нь төлийн талбайтай ойр учир дээрх станцын мэдээллийг ашиглав.

Геоморфологийн хэв шинж

Улаанбаатарын районд рельефийн гарал үүслийн тектоник-денудаци, денудаци-хуримтлал, хуримтлалын төрөл ялгагдана.

Улаанбаатар хотод улирлын ба олон жилийн цэвдэг ул хөрс, чулуулаг тархсан байдаг. Манай орны цэвдэг дэлхийн бөмбөрцгийн хойд хагаст тархсан олон жилийн цэвдгийн өмнөд хил болдог учраас Сибирийн мөнх цэвдгийг бодвол өндөр температуртай, байгалийн хүчин зүйл болон хүний зохисгүй үйл ажиллагааны нөлөөнд амархан өртөж хувирч өөрчлөгддөг онцлогтой. Ийм учраас тус газарт тархсан улирлын ба олон жилийн цэвдгийг судалж түүний нөлөөнөөс урьдчилан сэргийлж байгаль хамгаалахад цэвдгийн нөхцөлийг зайлшгүй тооцож байх шаардлагатай.

Геологийн тогтоц

Геологийн тогтоцын хувьд Улаанбаатар хотын район Монгол орны геологи тектоникийн ангиллын Хэнтийн геосинклиналь хотгорт харьяалагдана. Районы геологийн тогтоцод доод карбон, доод цэрд, неоген, дөрөвдөгчийн хурдас чулуулаг, доод мезозойн интрузи бүрдэл оролцоно.

Улаанбаатарын дүүргүүдийн нийтэд нь хамруулж хийсэн судалгааны ажлын үр дүнг энд голчлон оруулсан болно.

Доод карбонь чулуулаг (C₁): Районд тархах чулуулгийн дотроос хамгийн эртнийх нь болох доод карбонь чулуулгууд Богд уулын хойт хажуу, Туул голын хойт хэсгийн уулсын геологийн тогтцыг бүрдүүлж өгнө. Энэ насны чулуулгуудад алевролит, элсэн чулуу, конгломерат, гравелит, яшма маягийн цахиурлаг чулуулгууд зонхилон оролцоно.

Доод цэрдийн чулуулаг (K₁): Доод цэрдийн настай чулуулаг Туул голын грабенийг дүүргэн тогтсон нь анхны геологийн судалгаанаас мэдэгдэж байсан бөгөөд газрын гадарга дээр Толгойт, Мааньтын овооны хавиар ил гарч иржээ. Литологийн найрлагаар нь дээд ба доод гэсэн 2 горизонт болгон ангилагджээ.

Неогены хурдас (N): Неогены хурдас Туул голын грабены хэмжээнд доод цэрдийн чулуулгийн дээр байрлаж тархах бөгөөд газрын гадарга дээр Тасган овоо, Наран, Мааньтын овоо, Толгойт, Улаан хуаран, Шар хад зэрэг газраар ил гарч ирсэн байна. Толгойтын “Найрамдал” карьерт хийсэн судалгаанаас үзэхэд неогены зүсэлт хоёр зузаалагаас тогтдог байна.

Дөрөвдөгчийн галавын хурдас: 1986 оны “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн 1:10000 масштабтай инженер геологийн зургийн тайлбар бичиг”-т тус районд тархсан сэвсгэр хурдасны гарал үүслийн ангилал хийж дөрөвдөгчийн хурдсыг ялгасан байна. Үүнд: Нийт гарал үүслийн үндсэн 6, холимог 5 төрлийг ялгасан ба насны 4 хязгаарыг тогтоосон байна.

Элюви-делювийн хурдасны геологи гарал үүслийн комплекс (eaQ)

Ангилалдаагүй дөрөвдөгчийн настай элюви-делювийн хурдас нь дунд ба нам өндөрлөг уулсын хажуу хэсэгт доод карбоны кристалл фундаментийг хучиж өргөн тархана. Усан хагалбарын хажуугийн дээд хэсэг болон доод карбоны чулуулаг гадаргад ойр орших хажуугийн дунд-доод хэсгийн налуу багатай гадаргууд газрын гадаргад шууд илрэх ба хажуугийн бусад хэсгүүдэд делювий, делюви-пролювийн хурдас харилцан адилгүй зузаантай хучсан байдаг.

Элюви-делювийн хурдасны зузаан янз бүр, Баянхошуу ба Маахуур толгойн районд 0.5-6.0м, Буянт-ухаагийн районд 1.0-15.0м хүртэл зузаантай оршино. Хурдасны бүрэлдэхүүнд элс, шаварлаг материалаар чигжигдсэн хайрган хөрс өгөршлийн бүсэд хэмхдэс материалыг агуулсан шавранцар, шавар тохиолдоно.

Дунд-дээд дөрөвдөгчийн флювиогляциаль хурдасны геологи-гарал үүслийн комплекс (fQII-III)

Флювиогляциаль-мөстлөгийн гаралтай хурдас Хүрхрээгийн амны адагт тархсан. Уг хурдасны бүтэц, бүрэлдэхүүн, шинж чанарын талаархи мэдээ материал ховор бөгөөд гадаргын хэсгээрээ бага зузаантай делювийн шавранцараар жигд хучигдсан байх ба том бул чулуу гадаргад их хэмжээгээр илэрч тархсан байна.

Дунд-дээд дөрөвдөгчийн аллюви-пролювийн хурдасны геологи-гарал үүслийн комплекс (ar QII-III)

Уг комплексийн хурдас чулуулаг Сэлбэ, Улиастай, Толгойт, Хонхорын грабенийг хучин дүүргэхээс гадна Зайсан, Их тэнгэр, Бага тэнгэрийн амны ёроолыг хучин тархана. Хурдасны зузаан Сэлбэ, Улиастай, Толгойт, Хөлийн голын хөндийд 17-30 м, Зайсангийн амны адагт 70 м хүрэх ба шавранцар, сайргархаг шавранцар болон шаварлаг хөрсний үеүд агуулсан элсэнцэр, шавранцараас чигжигдсэн сайр сайрган хурдсаас бүрдэнэ.

Делювийн хурдасны геологи-гарал үүслийн комплекс (QIII-IV)

Дээд дөрөвдөгч орчин үеийн делювийн хурдас уулын хажуу, бэл хормойн хэсгээр маш өргөн тархах бөгөөд элюви-делювийн хурдас болон үндсэн чулуулгийг хучин тогтоно. Хурдсын бүрэлдэхүүнд элсэнцэр шавранцараар чигжигдсэн хайр, хайрга, хайргархаг элсэнцэр, шавранцар зонхилох ба ховроор элс тохиолдох бөгөөд зузаан нь хажуугийн дээд хэсгээс доошоогоо ихсэж 1-15м хүрнэ.

Делюви-пролювийн хурдасны геологи-гарал үүслийн комплекс (arQIII-IV)

Дээд дөрөвдөгч орчин үеийн настай делюви-пролювийн хурдас усан хагалбарын хажуугийн доод хэсэг, налуу багатай өргөн уужим бэл хормойд өргөн тархана. Тухайлбал: Нисэх, Яармаг болон судалгааны талбайн баруун хойт хэсгийн Туул голын хөндийд тулж ирсэн уулын жижиг амуудын адгийг хамрах бөгөөд хөрсний ба байгалийн бусад нөхцлөөрөө барилга байгууламж барихад хамгийн тохиромжтой талбай юм. Уг

комплексийн хурдсын бүрэлдэхүүнд шавранцар ба элсэнцрээр чигжигдсэн том хэмхдэс, шавранцар, хайргархаг элсэнцэр зонхилно.

Дээд дөрөвдөгч-орчин үеийн аллюви-пролювийн хурдасны геологи-гарал үүслийн комплекс (ар Q_{III-IV})

Уг комплексийн хурдас Чингэлтэй, Хайластын ам, Баянголын хөндийд тархана. Хурдасны зузаан уулын ам, хөндийн хэсэгт 10м, түүнээс их байх ба сайргархаг шавранцар, элсэнцэр болон шавранцараар чигжигдсэн бул чулуу агуулсан сайр сайрган хурдас бүрхэнэ. Улирлын хөдөлтийн гүн 2.8-4.1м (эхнийх сайргархаг шавранцар, 2 дахь нь шавранцараар чигжигдсэн сайр, сайрга).

Аллювийн хурдасны геологи-гарал үүслийн комплекс (аQ_{III})

Уг комплексийн хурдаст Туулын грабенийг дүүргэсэн аллювийн хурдасны дээд свитын дээд зузаалаг шавранцар, элсэнцэрийн үеүд агуулсан сайр хурдас зонхилох ба зарим хэсгүүдэд (Цагаан хуарангийн район) элсэнцэр, шавранцраар чигжигдсэн байдаг. Хуучин гольдролын орчин буюу нам татмын хэсэг мөн хөндийн зарим хэсэгт бага зузаантай (0.5-2м, хааяа 3м хүртэл) татмын шаварлаг хурдсаар хучигдсан байна.

Проллювийн хурдасны геологи-гарал үүслийн комплекс (рQ_{IV})

Голоцены пролювийн хурдас гуу жалгын ёроол, адгийн хушуу туугдас, уулын хажуугийн хормой, мөрөгцөгийн ёроолыг хучиж орчин үеийн хаяавч хурдсыг үүсгэх бөгөөд элсэнцэр, шавранцар, хайр, хайрган хурдсаас бүрдэнэ. Гуу жалгын ёроолоор хайргархаг элсэнцэр ба элс, хушуу туугдасын хэсэгт хайр хайрга ба шавранцар, уулын бэл хормой ба мөргөцгийн ёроолоор хайр хайрга агуулсан элсэнцэр, шавранцар зонхилон тархана. Зузаан нь гуу жалгын эх, дунд хэсэгт 1-3м, адгийн хушуу туугдас ба уулын бэл хормойн ёроолд 7м хүрнэ.

Техноген хурдас (zQ_{IV})

Улаанбаатарын районд хүн ам суурьшин төвлөрч хот суурин байгуулагдаж эхэлснээр асгамал хөрс үүсч эхэлсэн байна. Тухайлбал: Сэлбийн хөндийн адгийн хотын төвийн орчин, 12, 15, 3, 4-р хороолол, Туул голын хөндийн үйлдвэр, орон сууцны хороолол төвлөрсөн хэсгийг дурьдаж болно. Асгамал хөрс нь уулын хажуугийн идэгдлийн сүлжээг дарж босоо төлөвлөлт хийн барилга байгууламж барих Дэнжийн мөрөгцөгийг тэгшилж засах, Далан шуудуу, зам барих, голын хуучин гольдролыг дарж тэгшлэх, барилга байгууламжийн суурь, инженерийн шугам сүлжээний нүх ухаг гаргасан шороог тэгшилж тараах, мод зүлэг тарих зэрэг ажлын явцад үүсч бүрэлдэж байна.

Тектоникийн хэвшлүүд

Улаанбаатарын районы тектоник тогтоц Хэнтийн уулархаг нутгийн неотектоник хөгжилтэй шууд холбоотой бөгөөд неоструктурын ерөнхий төлөвийг Улаанбаатарын грабен түүнийг хүрээлэн орших блоклог өргөгдлүүд тодорхойлно. Тектоник тогтцын хувьд тус нутаг энгийн бөгөөд мезозойн өмнөх ба мезокайнозойн структурын давхаргуудаас тогтоно.

Мезозойн өмнөх структурын давхарга нь тус нутгийн кристаллаг фундаментыг үүсгэх бөгөөд түүний бүрдэлд доод карбоны тунамал чулуулгийн комплекс зонхилох ба гол төлөв зүүн хойд, баруун хойд чиглэлтэй тектоник хагралуудаар хэрчигдэж дотоод тогтоц нь нийлмэл болсон байна.

Мезокайнозойн структурын давхарга нь кристаллаг фундамент дээр үүсч гол төлөв томоохон голын грабен хэлбэрийн хөндийнүүдийг дүүргэж оршино. Структурын энэ

давхаргын дотоод тогтцыг доод цэрд, неоген, дөрөвдөгчийн структур, формацын комплексүүд бүрдүүлнэ.

Тус нутгийн тектоник тогтцод түрүү мезозойн интрузив комплекс бие даасан структурыг үүсгэсэн байна.

Улаанбаатарын районы тектоник структурыг гүний хагарлууд тодорхойлж структурын давхаргууд гол төлөв гүний хагарлуудаар зааглагдана. Улаанбаатар хот орчмын нутаг нь 7-8 баллын хүчтэй газар хөдлөлийн мужид хамаарна. Үйлдвэрийн нутаг дэвсгэр нь чичирхийллийн 8 баллын ангилалд багтаж байна.

Дөрөвдөгчийн хурдасны тархалт

Архангай аймгийн Өндөр-Улаан сум Дөрөвдөгчийн ангилагдаагүй хурдас мөн орчин үеийн хурдас тархсан. Чулуут сумтай хиллэж буй хэсгээр -Дээд дөрөвдөгч орчин үеийн/голын/, дөрөвдөгчийн ангилагдаагүй хурдас, эльвийн десерцийн, делювийн дөрөвдөгч ангилагдаагүй хурдас, өмнө хэсгээр- Нуур голын дээд дөрөвдөгч, дээд дөрөвдөгч орчин үеийн хурдас, баруун хэсгээр- Эльвийн дөрөвдөгч ангилагдаагүй хурдас, зарим хэсэгтээ коллювийн хурдас бүхий Дөрөвдөгчийн өмнөх үеийн чулуулаг, дээд дөрөвдөгчийн хурдас тархсан байна.

Газар чичирхийллийн муж

Архангай аймгийн Өндөр-Улаан сум газар чичирхийллийн муж- 8-9 балл ба газар хөдлөлтийн голомт үүсэж болох бүс /Рихтерийн шатлалын магнитуд/ талбайгаа- 6.6-7, шугаман- 6.6-7.0 хүчтэй газар хөдлөлтийн бүсэд багтдаг.

Туул голын сав газрын ус зүйн сүлжээ

Туул голын сав газарт 127 голын ус хурах талбайг үзүүлсэн бөгөөд голуудын 43 нь Туул голын зүүн гар талаас 84 нь баруун гар талаас нийлж байна. Эдгээр голуудыг Р.Э Хортоны ангиллаар эрэмбэлэхэд Улаанбаатар хотоос дээш Туул гол 5-р эрэмбийн гол болох ба Тэрэлж, Хаг голууд 4-р эрэмбийн, Хонгор, Хөл, Заан, Баруунбаян гэх мэт 8 гол 3-р эрэмбийн, ус хурах талбайгаар нь ялгасан Түргэн, Налайх, Хийд, Бөхөг гэх мэт 58 гол 2-р эрэмбийн голуудыг үүсгэж байгаа 994 жижиг гол горхи ба түр урсацтай тасардаг, хуурай сайр 1-р эрэмбэд орно.

Туул голын хур тунадас голдуу зуны улиралдаа орно. Түүний хэмжээ олон жилийн дундаж байдлаар жилдээ 222 мм-аас 275 мм хэлбэлзэж ойролцоогоор 68-74% нь зуны улиралд бороо байдлаар ордог байна. Мөн орох хур тунадас ихэнхдээ аадар шинжтэй учир хоногийн хамгийн их хэмжээ аадар бороо орох үед ажиглагддаг.

Голын усны нөөц, горим

Хан Хэнтийн нурууны өврийн далайн түвшнээс 2200м-ийн өндрөөс эх авах Номин гол, салбар уулс болох далайн түвшинээс дээш 2154м өндөрт өргөгдсөн Шороотын давааны өврөөс эх авсан хоёр голын бэлчирээс эх авна. Хэнтийн нурууны салбар уулсаас эх авсан Галтгай, Сарьдагийн Хийд, Хаг, Хонгор, Зүүн Баян, Тэрэлж, Хөлийн гол, Улиастай, Сэлбэ зэрэг гол горхи Туул голд цутгана. Голын ус хурах талбай 49900 км², урт нь 874 км, ус хурах талбайн дундаж өндөр 1474м, гулдиралын ерөнхий хэвгий 1.3% юм. Туул нь Орхон голын баруун гарын хамгийн том цутгал бөгөөд Орхон голын сав газрын 38%-ийг эзэлнэ.

Голын усны найрлага, чанар

Манай орны томоохон голуудаас экологийн өөрчлөлтөд хамгийн ихээр өртөж байгаа нь Туул гол бөгөөд 2019 оны 1 дугаар сард хийсэн судалгаагаар усны чанарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу Туул голын хяналтын шинжилгээний Уубулан, Налайх,

Сонгино доод, Хаданхясаа, Алтанбулаг цэгээс тус бүр 1 сорьц авч, усны химийн найрлага, чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлсон шинжилгээний дүнгээс үзэхэд: Улаанбаатар хотоос дээш хэсэгт Туул голын усны эрдэсжилт дунджаар 80мкСи/см, хотоос доош буюу Сонгиноос Алтанбулаг хүртэлх хэсэгт эрдэсжилт 11-14 дахин их байлаа.

Гадаргын усны хяналт-шинжилгээ

Гол мөрөн нуурын усны нөөц чанар горимын хувьсал өөрчлөлтийн зүй тогтлыг тохиолдлын чанартай цөөхөн хэмжилтээр бүрэн илэрхийлэх боломжгүй бөгөөд гол мөрний горим нөөцийг үнэн бодитой үнэлэх хамгийн гол нөхцөл үндсэн суурь бол шаардлага хангасан гадаргын усны ажиглалт, хэмжилтийн сүлжээтэй байх явдал юм. Монгол оронд гадаргын усны ажиглалт хэмжилтийн сүлжээний нягтшилтай холбоотой тусгайлсан стандарт байхгүй бөгөөд Дэлхийн цаг уурын байгууллагаас гаргасан гол мөрний харуулын байж болох хамгийн бага нягтшилын зөвлөмжийг мөрдлөг болгодог. Уг зөвлөмжөөр хамгийн багадаа уулархаг бүс нутагт 1000 км², тал хээрийн ухаа толгод бүхий бүсэд 1875 км², туйлын болон говь цөлийн бүсэд 2000 км² тутамд ус судлалын 1 харуул ажиллаж байж ажиглалт хэмжилтийн нарийвчлалыг хангах бололцоотой гэж үздэг. Туул голын сав газарт гадаргын усны байнгын ажиглалт хэмжилтийг 1942 онд Туул гол дээр. Улаанбаатар хотод ус судлалын харуул байгуулснаар эхэлж өнөөг хүртэл тасралтгүй 78 дахь жилдээ ажиллаж байна. 2018 оны байдлаар Туул гол болон түүний цутгал голууд дээр нийт 9 харуул бүхий ажиглалт хэмжилтийн сүлжээ ажиллаж байна.

Гидрогеологийн судалгааны байдал: Улаанбаатар хотод 1930-аад оны үеэс эхлэн газрын доорх усыг ашиглаж эхэлсэн ба цаашид ч илүү ашиглах шаардлагатай болсон. Үүнтэй холбоотойгоор хот орчмын орчмын гидрогеологийн судалгаа нэлээд эрчимтэй хийгдэж эхэлсэн. Голчлон тухайн ЗХУ-ын олон байгууллагууд судалгаа хийж байсан. Эдгээр судалгааны хамгийн оргил судалгаа нь 1977-1979 онд Барилга-Архитектурын удирдах газар, Усны аж ахуйн удирдах газрын захиалгаар ПНИИИС Улаанбаатар хотын техникийн болон унд-ахуйн ус хангамжид зориулан Туул голын хөндийн хөрсний усны /грунтовых вод/ ашиглалтын нөөцийг үнэлэх гидрогеологийн цогц /геологи-гидрогеологи-гидрологийн/ судалгааны ажил явуулжээ. Энэхүү судалгааны ажил нь Тэрэлж-Туулын бэлчирээс эхлэн Алтанбулаг сумаас цааш байрлах Их цагаан аралын баруун булан хүртэлх нийт 94 км урт үргэлжилсэн талбайг хамран хийгдсэн. Судалгааны талбайгаа 3 хэсэг болгон хуваажээ. Тэрэлж-Туулын бэлчирээс Гачуурт хоорондох талбайг дээд хэсэг /19.0 км/, Гачууртаас Сонгинын булан хоорондох талбайг Төвийн хэсэг /35.0 км/, Сонгинын булангаас Их цагаан аралын булан хүртэлх талбайг Доод хэсэг /40.0 км/ гэж үзжээ. Дунд хэсгийн уст давхаргын зузаан 16.5-67.6 м хооронд хэлбэлзэх ба дунджаар 35.0 м гэж тогтоосон байдаг. Мөн шүүрэлтийн итгэлцүүр 10.0-139.0 м/хоног, дунджаар 55.0 м/хоног байна гэж тогтоосон. 1990-1992 онуудад Г.Өнөдэлгэр, Б.Банзрагч, Т.Сэнгэдорж нар Улаанбаатар хот орчимд геологи-гидрогеологи, геофизик, геохимийн цогц судалгаа явуулж үр дүнд нь газрын доорхи усны ашиглалтын нөөцийг үйлдвэрлэлийн зэргээр тогтоосон байна.

Гидрогеологийн нөхцөл: Сав газрын хэмжээнд нүх сүвийн бүрдэл, ан цавын бүс гэсэн үндсэн 2 төрлийн ус агуулагч бүрдэл тархсан ба ан цав-нүх сүвийн ус болох рашаан тархсан байна. Нүх сүвэрхэг бүрдэл нь доод цэрд, неоген, дөрөвдөгчийн хурдас дотор, ан цавлаг бүс нь кембри, девон, карбоны тунамал, хувирмал эсвэл юра, триассын түрмэл чулуулаг дотор тус тус бүрэлддэг. Туул голын сав газрын хэмжээнд тархсан хурдас чулуулгийн нас, литологийн төрлийг нэгтгэж, тэдгээрийг нүх сүвшилт зонхилсон эсвэл ан цавшилт зонхилсон байдлаар нь ангилж, газрын доорхи усны судлагдсан түвшин, хөдөлгөөний төрхийг харгалзан уг сав газрын хэмжээнд ус агуулагч нүх сүвэрхэг 6 бүрдэл, ан цавлаг 2 бүсийг ялгав.

Хөрсөн бүрхэвч: Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Улаанбаатар хот орчмын газар нь Хангайн хөрс биоуур амьсгалын их мужийн чийглэг өндөршлийн бүсшил бүхий Төв Хэнтийн тойргийн өмнөд хэсэгт орших тул ууландаа уулын ширэгт тайгын хөрс, уулын ойт бараан ба уулын хар шороон хөрс, ам хөндийгөөр нь хар шороон, нугат-хар шороон хөрс зэрэг хэв шинжид хамрагдах хөрсний төрлүүд тогтворжсон байна.

“Хатансүйх импэкс” ХХК-ний үйлдвэр нь Туул голын хөндийн нам дэнжид байрлах бөгөөд аллювийн хөрс зонхилно.

Үйлдвэрийн талбайн орчмын гадаргын хөрс хайрга, хайрганцар үелсэн хурдас дээр тархах бөгөөд хөрсний тогтворжилтонд Туул голын усны горимтой холбоо бүхий ул хөрсний усны нөлөө, гадаргын жигд биш байдалтай (голын татмын дагуух янз бүрийн дэнж, хуурай татуурга, өндөр нам, элс хайрган далан, хотос хонхор гадаргуу) уялдсан хөрс үүсвэрийн үйл явцаас шалтгаалан энд тархсан аллювийн хөрсийг аллювийн ширэгт хөрс, аллювийн нугын хөрс, аллювийн нугат намгийн хөрсний хэв шинжүүдэд хувааж үзэх үндэслэлтэй боловч Туул голын усны татралт, ойр орчмын хөрсний элэгдэл, эвдрэл зэргээс шалтгаалан аллювийн хар хүрэн, хүрэн, хайргархаг элсэнцэр хөрс зонхилон тархах шинжүүд илэрсэн байна.

Тус үйлдвэрийн газрын төлөв байдал нь ихэвчлэн барилга байгууламж, хатуу хучилттай зам талбайгаар хучигдаж, сул шороон хөрс нь хүний үйл ажиллагааны нөлөөнд бүрэн өртсөн байна. Харин үйлдвэрийн хашаан дахь талбай нь 100% цементээр хучсан талбайтай байна.

Ургамлан нөмрөг: Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 4-р хороо үйлдвэрийн бүсэд байрлах “Хатансүйх” ХХК-ний хиам, махан бүтээгдэхүүний үйлдвэрийн байрны объектуудын орчимд ургамлан нөмрөгт судалгаа хийж, газрын төлөв байдал, ургамалжлын хэв шинжүүдийг тогтоох бичиглэл хийсэн. “Хатансүйх” ХХК-ний үйлдвэрийн эзэмшлийн талбай нь техноген нөлөөлөлд бүрэн өртсөн, цементэн хучилттай учир ургамалжлын хэв шинжийг тогтоох бичиглэлийг үйлдвэрээс урд зүгт 100-200 метрийн зайд хийлээ.

Хүснэгт 1. Бичиглэл хийсэн цэгүүдийн газарзүйн байрлал

Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг
1	106°50'20,78''	47°53'51,53''
2	106°50'14,50''	47°53'50,97''

Газрын гадаргуу: Нийт газрын гадаргуу тэгшивтэр тал.

Судалгааны арга зүй

- ▲ **Зүйлийн бүрэлдэхүүн:** Ургамалжлын зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо зүйлийн бүрэлдэхүүнийг флорын баялаг тодорхойлох аргаар бүртгэж, зүйлийн латин, Монгол нэрийг И.В.Грубовын (1982) бүтээлд зааснаар тус тус нэрлэсэн.
- ▲ **Арви:** Ургамалжлын зүйлийн арвид О.Друдегийн нүдэн баримжааны аргаар үнэлгээг өгсөн.
- ▲ **Тусгаг бүрхэц:** Ургамалжлын зүйлийн тусгаг бүрхэцийг Раменскийн 1м²-ийн хэмжээст тороор тодорхойлсон.



Зураг 1. Ургамалжлын тусгаг бүрхэцийн хэмжилт.

- ▲ **Өсөлт:** Ургамлын өсөлтийг тодорхойлохын тулд өндрийг сантиметрийн хэмжээст шугамаар газрын хөрснөөс дээш 0см-ийн өндөрт хэмжсэн.
- ▲ **Ургац:** Ургацыг 3 давталттайгаар 1м² талбайгаас газрын хөрснөөс дээш 0см-ийн өндөрт хайчилж нойтон, агаарын хуурай жинг жигнэж тодорхойлсон.
- ▲ **Ургамалжил.** Улаанбаатар хот нь ургамал газарзүйн мужлалаар Евро-Азийн хээрийн их муж, Дагуур Монголын (Төв Азийн) дэд их муж, Дагуур-Монголын уулын ойт хээрийн муж, Орхон-Сэлэнгийн дэд мужид хамаарагдана.(БНМАУ-ын үндэсний атлас, 1990он).

Ургамалжлын зүйлийн бүрэлдэхүүн

Судалгаа явуулсан газар нь уулын хээрийн Хялгана- алаг өвс бүлгэмдэл (*хуучнаар*), одоогийн төрх байдал нь Адамсийн буюу явган Шарилжит бүлгэмдэлд болсон байлаа. Уг бүлгэмдэлд 11 овгийн 18 төрлийн нийт 25 зүйл ургамал бүртгэгдсэн. Эдгээр ургамлууд нь амьдралын хэлбэрийн хувьд мод-2, сөөг-4, сөөгөнцөрлөг-2, олон наст өвс-12, хоёр наст-1, нэг наст-4 зүйл ургамал тус тус тэмдэглэгдэв.

Амьтны аймаг: Тус нутагт амьтан ургамлын аймгийн экосистемийн шинж төрх алдагдаж энэ хавийн амьтны зүйлийн бүрдэл нь хот суурин, хүний ойр орчимд амьдрах синантроп зүйлүүд суурьших болжээ. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн төв хэсэгт амьтны аймгийн төрөл зүйл аль хэдийн байгалийн нутагшил, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдаж зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад байгаа болно.

Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэр, эрчим хүч, үйлдвэрийн бүсэд явуулсан богино хугацааны судалгаа (гадаргын усны далан, гол горхи, авто зам, овоолгоотой шороо зэрэг экологийн элдэв нөхцөл бүхий хэсгийг хамарсан 1-2 км замналаар), иргэдийн аман мэдээ, хэвлэлийн хомс баримтад тулгуурлан амьтны аймгаас хамгийн өргөн тархсан 34 зүйлийн шавж, 17 зүйлийн шувуу, 4 зүйлийн хөхтнийг олж тодорхойллоо.

Эдгээрийн дотор Монгол Улсын Улаан ном (1987)-д орсон ховор, ховордож буй, Вашингтоны конвенц (CITES)-ийн 2-р хавсралтад хамрагдсан амьтан үгүй болно. Энэ

орчимд шувуудын дотроос тоо толгойн хувьд оронгийн (*P.domesticus*) ба хээрийн (*P.montanus*) бор шувуу, хөхвөр тагтаа (*C.livia*), Сохор элээ (*Milvus migrans*), Шаазгай (*Pica pica*), Улаан хошуут (*Pyrhcorax pyrrhcorax*), Хар хэрээ (*Corvus corone*), Хон хэрээ (*Corvus corax*) арай олон үзэгдэж байлаа.

БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

БОННУ-ний тайлангийн Бүлэг-2-т Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 4-р хорооны нутаг дэвсгэрт орших “ХАТАНСҮЙХ ИМПЕКС” ХХК-ний “Хиам, махан бүтээгдэхүүний үйлдвэр” төслийн байгаль орчин болон тухайн нутгийн ард иргэд, оршин суугчдад нөлөөлөх нөлөөллийн талаар тусгасан болно. Сөрөг болон зайлшгүй гарах нөлөөллийг хэрхэн багасгах, бууруулах арга хэмээ, зөвлөмжийг БОННУ-ний тайлангийн Бүлэг-3-т тусгасан ба төсөлд ашиглагдах шатах тослох материалаас үзүүлэх нөлөө, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн үнэлгээ, менежмент хэсэгт тусгасан. Болзошгүй нөлөөлөл, тэдгээрийг хэрхэн багасгах, бууруулах арга замуудыг тус бүрд нь товч өгүүлэв.

4.1. АГААРЫН ЧАНАР

Болзошгүй нөлөөлөл. Уур амьсгалын эрс тэс байдал нь бэлэн бүтээгдэхүүн хадгалахад нөлөөлөл учруулж болзошгүй. Үйлдвэрийн үйл ажиллагаанаас агаарын чанарт доорх нөлөөллүүд учирч болзошгүй. Үүнд:

- Түүхий эд, туслах материал, бэлэн бүтээгдэхүүн тээвэрлэх машины яндангаас гарах хорт утаа
- Хог хаягдлаас үүсэх үнэр хэр хэмжээтэй байгаагаас хамаараад нян бактери үржих, орчин тойронд эвгүй үнэр тархах, амьдрах орчин доройтох зэрэг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

Нөлөөллийг бууруулах арга зам.

- Гадаад орчны тоосжилтыг дарах зорилгоор усалгааг тогтмол хийж байх, усалгааг хийхдээ хуурайшилт ихтэй 4-9 саруудад, хуурайшилт ихтэй өдрүүдэд усалгаа хийх бөгөөд үйлдвэрийн гаднах орчныг бүрэн хамруулах зүйтэй юм.
- Гадаад орчны усалгааны багаж хэрэгсэлтэй болох
- Ажилчдад амны хаалт, хошуувч, маскийг тогтмол зүүлгэж хэвшүүлэх, хор тайлах бүтээгдэхүүнээр тогтмол хангах, тээврийн машинуудын кабины битүүмжлэлийг сайжруулах, хяналт шалгалт тогтмол хийх,
- Машин механизмыг удаан хугацаагаар асаалттай орхихгүй байх
- Түлшний дутуу шаталтаас гардаг хар утаа хаясан механизм ажиллуулахгүй байх
- Хог хаягдлыг шатаахыг хориглох
- Үйлдвэрээс гарсан хаягдал орчинд эвгүй үнэр тархах, амьдрах орчны тав тухыг алдагдуулахаас сэргийлэх арга хэмжээ авах.

4.2. ХӨРСӨН БҮРХЭВЧ

Болзошгүй нөлөөлөл Тус үйлдвэрийн орчмын газрын төлөв байдал нь ихэвчлэн барилга байгууламж, хатуу хучилттай зам талбайгаар хучигдаж, сул шороон хөрс нь хүний үйл ажиллагааны нөлөөнд бүрэн өртсөн байна. Харин үйлдвэр нь өөрийн эзэмшлийн талбайг цементлэн хучсан бөгөөд үйлдвэрийн талбай нь 100% техноген нөлөөлөлд өртсөн байна.

- Ахуйн хог хатуу хаягдал болон үйлдвэрийн хатуу, шингэн хаягдлаар хөрс бохирдох
- Хөрс бохирдсоноор физик шинж чанар нь алдагдсанаар хөрс хуурайших, хөрсний биологийн нөөц хомсдох, үржил шим нь алдагдах.

Болзошгүй нөлөөлөл, бууруулах арга хэмжээ.

Төслийн үйл ажиллагаанаас газрын хэвлийд үзүүлэх нөлөөлөл харьцангуй бага бөгөөд газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Үүнд:

- “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль”-ийн 7.2.1-р заалтад “...Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон цэгээс бусад газарт хөрсийг хог хаягдлаар бохирдуулахгүй байх” заалтыг хэрэгжүүлэх,
- Үйлдвэрийн гадаад орчныг зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр хийгдэх арга хэмжээ (машин техникийн тээвэрлэлт хийх, түүхий эд материалыг ачиж буулгах талбайг тодорхой болгож тэмдэгжүүлэх, ашиглагдахгүй талбайд ажилчдын амарч, тухлах орчныг бий болгох)
- “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль”-ийн 7.2.4-р заалтад “...Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн болон өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх” заалтыг хэрэгжүүлэх.
- Төслийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатайгаас бусад шалтгаанаар газрын хэвлий, гадаргуугийн дүр төрхийг өөрчилж, хөндөхгүй байх, цаашдын газар зохион
- Төслийн хэрэгжилтийн шатанд ашиглагдаж буй машин техник тоног төхөөрөмжөөс гарч буй хорт хийн хэмжээ стандарт шаардлагад нийцэж байгааг шалгах, стандартаас илүү хорт хий ялгаруулж буй машин техникийг засварлах, ашиглахгүй байх, хөрсөн бүрхэвчийн бохирдлыг хянаж байх
- Эзэмшил газрыг зориулалтын дагуу ашиглах, газрын төлбөрийг гэрээний дагуу хугацаанд нь төлөх, газар ашиглах гэрээг жил бүр дүгнүүлэх, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх шаардлагатай.
- Төслийн явцад хөрсийг ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлаар бохирдуулахгүй байх

4.3. УРГАМЛАН НӨМРӨГ

Орчны тохижилт: Үйлдвэрийн хашааны сул чөлөөтэй талбайг үр ашигтай ашиглах, орчны тохижилтыг бий болгохыг зөвлөж байна.

Төслийн талбайн хөрс ургамлыг элэгдэл эвдрэлээс хамгаалах, ногоон байгууламж байгуулах талаар дор дурдсан зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллахыг төсөл хэрэгжүүлэгчид зөвлөж байна. Үүнд:

- Барилга байгууламжийн үйл ажиллагаанаас талхлагдсан ургамал, элэгдсэн хөрсийг нөхөн сэргэх зорилгоор хар шороон хөрсийг зөөвөрлөн авчирч хөрсжүүлэх элэгдсэн хөрсийг байнга сэргээж байх
- Байгуулалтын ажлын явцад эвдрэлд орсон хөрсийг нөхөн сэргээж, барилга объектын талбайгаас бусад сул газрыг бүрэн хэмжээнд зүлэг ургах нөхцөлөөр бүрэн хангах, ургамалжуулах, тариалсан ургамлыг тухай бүр нь арчилж тордох арга хэмжээ авч хэрэгжүүлж байх
- Тарималжуулалтыг технологийн горимын дагуу явуулах шаардлагатай ба мэргэжлийн байгууллагаас технологийн нэмэлт заавар, зөвлөгөө авч хэрэгжүүлэх Аль болох тухайн орчинд ургадаг, дасан зохицох чадвартай мод, бут, сөөг, олон наст ургамлыг хольж тариалах нь зүйтэй.

4.4. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УС

Хиам, махан бүтээгдэхүүний үйлдвэрийн талбай нь гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх шууд нөлөөлөл үгүй юм. Үйлдвэр нь тоног төхөөрөмжийн ариутгал цэвэрлэгээнд

ашигласан техникийн хэрэгцээний усаа ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээнд нийлүүлдэг.

- Үйлдвэрийн хаягдал усны бохирдол нэмэгдэх
- Тоног төхөөрөмжийн ариутгал цэвэрлэгээнд ашиглах цэвэрлэгээ, ариутгалын бодис хэтрүүлэн хэрэглэх, ажилчдын хайнга үйлдлээс ариутгах татуургын шугам сүлжээнд нийлүүлж буй бохир ус стандарт үзүүлэлтээс давах
- Ариутгах татуургын шугам сүлжээнд эвдрэл гэмтэл гарснаар бохир ус үйлдвэрийн орчны хөрсөнд алдагдах

Болзошгүй нөлөөлөл, бууруулах арга хэмжээ.

Хиам, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн үйл ажиллагааны үе шатанд усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулахад дараах зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана. Үүнд:

- Тоног төхөөрөмжийн гэмтлээс болж шат дамжлагуудад усны алдагдал гарч болзошгүй учир хаалт, хавлагуудын бүрэн бүтэн байдлыг шалгаж, тэдгээрийг элэгдэж гэмтэхээс сэргийлэх арга хэмжээ авах.
- Үйлдвэрээс гарах бохир усны онцлог нь их хэмжээний өөх тос, цус, органик бохирдол агуулсан байдаг тул үйлдвэрийн хэсгээс гарах шугам хоолойд механик, физик цэвэрлэгээний сараалж, тос баригчид хяналт тавьж ажиллах шаардлагатай.
- Тоног төхөөрөмжийн урсгал засварыг тусгай графикийн дагуу хийж байх
- Хаягдал усны цэвэрлэгээний түвшин, чанар найрлагад мониторингийн хяналтыг тогтмол хийх
- Үйлдвэрийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх усны хэрэглээг норм стандартын дагуу ашиглах, усны хэмжээнд хяналт тавих,

БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“ХАТАНСҮЙХ ИМПЕКС” ХХК-ний “Хиам, махан бүтээгдэхүүний үйлдвэр” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол Улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай шинэчилсэн хууль, БОАЖСайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны А-117 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт болон БОАЖ Сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А-618 тушаалын хавсралтын дагуу холбогдох дүрэм журмын шаардлагад нийцүүлж боловсруулав.

5.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь албан ёсны баримт бичиг бөгөөд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн. Байгаль орчны хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд хяналт-шинжилгээний хөтөлбөрийн хариуг үндэслэн жил бүр шинэчлэн, сайжруулж байх шаардлагатай юм.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А-126 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 2.1-д *“Төлөвлөгөөт аудитыг хоёр жил тутамд, төлөвлөгөөт бус аудитыг Засаг дарга, эсхүл байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аудит хийлгэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хийнэ”* хэмээн заасны дагуу аж ахуйн нэгж өөрийн зардлаар аудит хийлгэнэ.

Байгаль орчин-эдийн засаг

“ХАТАНСҮЙХ ИМПЕКС” ХХК-ний “Хиам, махан бүтээгдэхүүний үйлдвэр” төсөл нь улс орон болон бүс нутгийн ашиг орлогыг нэмэгдүүлэхэд тодорхой үүрэг гүйцэтгэнэ. Улс орны төсөвт:

- Ашгийн татвар
- Хүн амын орлогын албан татвар
- АТӨЯХАТ
- Нийгмийн даатгалын шимтгэл зэрэг төлбөрүүдийг оруулна.
- Газар ашигласны төлбөр
- Нэмэгдсэн өртгийн албан татвар
- Ус ашигласны төлбөр ашиглахтай холбогдох татвар, төлбөрүүдийг оруулна.

Мөн байгаль орчныг хамгаалах зардлыг жил бүр үндсэн үйл ажиллагааны төсөвт тусгаснаар БОХТ ба БОХШХ-т тусгагдсан арга хэмжээнүүд бүрэн хэрэгжинэ.

Байгаль орчин-Удирдлага зохион байгуулалт

“ХАТАНСҮЙХ ИМПЕКС” ХХК-ний байгаль орчин хариуцсан ажилтан БОХТ болон БОХШХ-ийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийн үр дүн болон дараагийн жилүүдэд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан тайланг компанийн удирдлага болон байгаль орчин хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагад танилцуулах үүргийг хүлээнэ.

Байгаль орчны бодлого, зорилго

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчинд онцгой анхаарал тавьж түүнд нөлөөлж болзошгүй аливаа нөлөөллийг багасгах үүрэгтэй. Үйл ажиллагаагаа явуулж эхлэхээс өмнө өөрийн албан хаагчид болон хамтран ажиллах бусад байгууллагыг байгаль орчин хамгаалах бодлогод хамруулахаар төлөвлөх хэрэгтэй. Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг багасгах, байгаль орчны талаарх дүрэм журмыг биелүүлэх зэргээр өөрсдийн бүх албан хаагчид, гэрээлэгчид өөрсдийн үүргийг биелүүлж ажиллахаар төлөвлөгөөндөө тусгасан байх.

Хөрөнгө санхүүгийн эх үүсвэр

Жил бүрийн санхүүгийн төлөвлөгөөний байгаль орчин, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээний зардалд тусган зарцуулж байх шаардлагатай. Төлөвлөсөн зардлын хэмжээ нь тухайн жил бүр харилцан адилгүй тогтоогдох боломжтой тул тухай бүрд нь тодруулга хийн шинэчлэн тооцно.

Хүснэгт 2. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг
1	Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
2	Ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө	600.0
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	110.0
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	600.0
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	450.0
7	Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал	2.600
8	Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1.100
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нийт зардал урьдчилсан байдлаар (5 жилд)		5 460.0

5.2. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Цаашид хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөө: Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны үндсэн бүрдэл хэсгүүд (агаар, ус, хөрс, газрын гадарга, амьтан гэх мэт)–ээр тооцож гаргасан төслийн үйл ажиллагааны хугацаанд биелүүлэх дараах арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажуулан, хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн төлөвлөгөөнд байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, сэргийлэх арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан болно.

Хүснэгт Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал

Байгаль орчны бүрэлдэхүүн	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	
Агаар	Түүхий эд, материалыг ачиж, буулгах, хаягдлын талбайд үүсэх тоосжилт (PM10, PM2.5)	Гадаад орчны тоосжилтыг дарах зорилгоор усалгааг тогтмол хийж байх /зам талбайн усалгаа/	Үйлдвэрийн талбайгаар хязгаарлагдана.	60.0	4-9 сард долоо хоногт 1 удаа	
		Гадаад орчны усалгааны багаж хэрэгсэлтэй болох				
		Хатуу хог хаягдлын цэгийг засаж тохижуулах, хог хаягдлыг ангилж хийх зориулалтын тасалгаатай, хогийг ачиж, гэвэрлэх ажилд саад учруулахгүйгээр байршилтай, хогийн цэгийн орчимд тэмдэг тэмдэглэгээтэй байх шаардлагатай.	Хог хаягдлыг бууруулах менежментэд тусгагдсан			
	Үйлдвэрээс голчлон задрах хог хаягдал үүсэх бөгөөд хаягдлын буруу хадгалалтаас үүсэх эвгүй үнэр орчинд тархах, амьдрах орчин доройтох, ажилчдын анхаарлыг сарниулах, тав тухтай ажиллах нөхцөлийг алдуулах	Хатуу хог хаягдлыг ангилан хадгалах, зориулалтын саванд цуглуулах, хог хаягдлын цэгийг тохижуулах, ариутгал цэвэрлэгээг тогтмол хийх	Хог хаягдлын менежментэд тусгагдсан.			
	Тээвэрт ашиглаж буй машин техникээс үүсэж болзошгүй хорт хий	Тээвэрт ашиглагдаж буй машин техник тоног төхөөрөмжөөс гарч буй хорт хийн хэмжээ стандарт шаардлагад нийцэж байгааг шалгах, стандартаас илүү хорт хий ялгаруулж буй машин техникийг засварлах, ашиглахгүй байх	БОХШХ-т тусгагдсан хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх	Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан	Үйл ажиллагааны бүхий л үе шатанд	
		Төсөл хэрэгжих хугацаанд мэргэжлийн байгууллагаар агаарын сорьц авхуулан шинжилгээ хийлгэж, зөвлөгөө авч байх				
	Үйлдвэрийн технологи ажиллагаанаас үүсэж болзошгүй хорт хий	Үйлдвэрийн агааржуулах системийг сайжруулах, агаар солилцоог тогтмол хийх, вентилятор суурилуулах	Дотоод төлөвлөлтөөр			
		Ажилчдад амны хаалт, хошуувч, маскийг тогтмол зүүлгэж хэвшүүлэх, хор тайлах бүтээгдэхүүнээр тогтмол хангах,	Дотоод төлөвлөлтөөр			
Дотоод орчны агаараас агаарын сорьц авхуулан шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргаж байх, дүгнэлтэд үндэслэн цаашид хийх ажлын төлөвлөгөөг гаргаж байх		БОХШХ-т тусгагдсан				
Дотоод орчинд үүсэх дуу шуугиан, доргио чичиргээ		Ажилчдад сонсгол хамгаалах хэрэгсэл /чихэвч/ зүүлгэх, тоног төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээг тогтмол хийх, БОХШХ-т тусгагдсан хяналт-шинжилгээг хийж хэвших	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан			
Гадаргын болон газрын доорх усан	Бохир усны шугам хоолойн гэмтэл, хаягдлаас үүсэх урсац хөрсний усанд нэвчих, угаалга	Ахуйн бохир ус хөрсөнд алдагдахаас сэргийлэх, үзлэг хяналт тавих, ХАБ, байгаль орчны чиглэлийн сургалтууддаа энэ чиглэлийн мэдээллийг оруулах	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан			

орчин	цэвэрлэгээнээс гарсан бохир усыг ил задгай асгах зэргээр хөрсний усны чанарт нөлөөлөх	Бохир ус, урсац хөрсөнд алдагдсан тохиолдолд бохирдсон байдлаас шалтгаалан саармагжуулах, цэвэрлэх арга хэмжээ авахад бэлтгэх	Хөрсийг хусаж авах багаж, хүрз, элс, шороо зэргийг бэлдэх	50.0	Үйл ажиллагааны бүхий л үе шатанд
		Осол аваар гарсан үед нийслэлийн онцгой байдлын газар болон нийслэлийн байгаль орчны газарт яаралтай мэдэгдэхийн зэрэгцээ түүнийг усан хангамжийн эх үүсвэр болгон ашиглаж байгаа хүний хэрэглээг хязгаарлах нь зүйтэй бөгөөд зайлшгүй шаардлагатай тохиолдолд тэднийг нүүлгэн шилжүүлэх, ус хангамжийн шинэ эх үүсвэр бий болгох, нөхөн төлбөр төлөх зэрэг арга хэмжээг нэн яаралтай авч хэрэгжүүлэх шаардлага үүссэн үед хэрэглэх мөнгөн хуримтлал үүсгэх			Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгасан
	Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал хурын усаар угаагдаж, урсац үүсэх, хөрсний усыг бохирдуулах	Хог хаягдлын цэгийг урсац хөрсөнд нэвчихээргүй болгож засаж янзлах, бетон суурийн хамрах хэмжээг нэмэгдүүлэх			Хог хаягдлын менежментэд тусгагдсан.
Газрын гадарга, хэвлий, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг	Ахуйн болон үйлдвэрийн хатуу, шингэн хог хаягдлын нөлөөгөөр хөрсөнд бохирдол тархах	Хатуу хог хаягдлыг тусгай цэгт цуглуулах, гэрээлэгч компани зайлуултал тодорхой хяналт хийх			Хог хаягдлын менежментэд тусгагдсан
		Төсөл хэрэгжих хугацаанд хөрсний дээж авч, итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгүүлэх, зөвлөгөө авч байх			БОХШХ-д тусгагдсан
	Болзошгүй осол эрсдэл, галын аюулын үед үйлдвэрийн хөргөлтөд ашиглаж буй фреон бодис орчинд тархах, хорт хий ялгаруулах	Аваар, ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байх, ажилчдад осол, аваарын үед хэрэгжүүлэх ажил, үүргийн хуваарь гаргах, яаралтай үед байгаль орчныг хамгаалах багаж хэрэгсэлтэй байх.			Осол эрсдэлийг бууруулах арга хэмжээнд тусгагдсан
зардал Нийт (мян.төг)				110.0	

5.3. НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖ БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Хатансүйх Импэкс” ХХК-ний хиам, махан бүтээгдэхүүний үйлдвэр нь өөрийн эзэмшлийн нийт 4328м² талбайд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эзэмшлийн талбайг бүхэлд нь хатуу хучилттай болгож, барилга байгууламж барьсан байна. Харин үйлдвэрийн эзэмшлийн үйлдвэрийн хажууд 50м² талбайг зүлэгжүүлсэн байна.

Үйлдвэрийн барилгын үйл ажиллагаанд өртөөгүй Тус компанийн эзэмшлийн газар нь нийт 4328м² талбайтай бөгөөд эзэмшлийн талбайн 95 хувь бетонон хучилттай байх бөгөөд ногоон байгууламж байгуулах талбайгүй байна. Иймд тус компани нь харьяа дүүрэг, хороотой хамтран өөр шаардлагатай газарт эзэмшлийн талбайн 10 хувь буюу 382м² талбайд 2023 онд ногоон байгууламж байгуулах ажлыг зохион байгуулж ажиллана.

Хүснэгт Ногоон байгууламж төлөвлөгөөний зардал

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Ерөнхийлөгчийн санаачилсан “Нэг тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд ногоон төгөл байгуулах	Өөрийн эзэмшлийн талбайд 3 мод суулгаж арчилж тордоно.	Эзэмшлийн газарт	400.0	2023 онд
3	Ногоон байгууламжийн ургалт сайжруулах, хүнд машин механизм болон хүний үйл ажиллагаагаар хугарч гэмтэх, халцарч, зулгарахаас хамгаалах	Ургалтад анхаарал, хяналт тавих, усалгаа, тордолгоог байнга хийх, арга хэмжээг авах, ногоон байгууламжийн орчимд хаалт, хамгаалалт тавих/цэцэрлэг, зүлэг ногоо услах	Нийт ногоон байгууламжийн орчимд	50.0	2023 онд
4	Эзэмшлийн талбайн 10 хувьд ногоон байгууламж байгуулах	Мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	Төслийн талбайд	150.0	2023 онд
Нийт				600.0	

5.4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн төсөл хэрэгжиж буй газар нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 4-р хорооны нутаг дэвсгэрт үйлдвэрийн бүсэд байрлана. Үйлдвэрийн буруу үйл ажиллагаанаас осол аваар гарахаас бусад тохиолдолд оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх шаардлага үүсгэхгүй юм.

5.5. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн талбайд түүх соёлын дурсгалт зүйл байхгүй бөгөөд төслийн хэрэгжилтийн үед ямар нэг зүйл илэрсэн үед арга хэмжээ авна.

5.6. ХИМИЙН БОДИС, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Хатансүйх Импэкс” ХХК нь хиам, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэх үйл ажиллагааны үед үүсэж болзошгүй осол эрсдэлээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, гарсан хор уршгийг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Халдварт өвчин	Хог хаягдлын цэг болон үйлдвэрийн орчныг цэвэрлэх ариутгах ажлыг тогтмол хийх	Үйлдвэрийн бүс	200.0	2023 онд
	Ажилчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах	-	200.0	2023 онд
Үйлдвэрлэлийн болон автомашины осол	Үйлдвэрийн тоног төхөөрөмжтэй ажиллах ажилчдад мэргэжлийн өндөр хариуцлагатай ажиллахыг анхааруулах самбар, сургалт явуулах. Мөн үйлдвэрийн дотоод болон гадаад замд тээврийн хэрэгслээр зорчих дүрэм журмыг мөрдөж ажиллахыг тогтмол сануулж ажиллах	Үйлдвэрийн бүс	200.0	Төслийн хугацаанд
Нийт			600.0	

5.7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын менежмент гэдэг нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлын эх үүсвэрийг бууруулах, ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах бүхий л процессыг хянаж сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ юм.

Төсөл хэрэгжүүлэгч нь хог хаягдлын менежментийн хүрээнд цаашдын авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хог хаягдлыг газар дээр нь ангилан ялгах нөхцөл бололцоог хангаж ажиллах үүрэгтэй.

Эзэмшил газрынхаа ойр орчны цэвэрлэгээг тогтмол хийх, үйл ажиллагааны явцад үүсэх хог хаягдлыг тогтоосон цэгт хуримтлуулж тогтмол хугацаанд зайлуулах, ангилан ялгаж дахин ашиглах боломжтой хаягдлыг ашиглах, аливаа зүйлээр бохирдсон хог хаягдлыг саармагжуулах, галын аюулаас хамгаалах, хадгалалт хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хадгалахдаа хогийн сав болон хогийн цэгийг өнгөөр ялгаж зургаар тэмдэгжүүлснээр хуурай хог хаягдлыг стандартын дагуу ачиж, тээвэрлэх хадгалах нөхцөл бүрдэхээс гадна байгаль орчинд сөрөг нөлөөгүй бохирдолгүй амьдрах нөхцөл бололцоо бий болох юм.

Хатуу хог хаягдлаа ялган ангилсны ач холбогдол:


- ✓ Цаас, шил, мод, яс, хуванцар, металл, органик гаралтай хаягдлыг эргүүлэн ашиглах, дахин боловсруулах боломж бий болно.
- ✓ Орчныг бохирдуулах, устгал хийх хогны хэмжээ эрс багасна.
- ✓ Хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ачиж тээвэрлэх боломж бүрдэнэ.
- ✓ Хүн амын аюулгүй, цэвэр, эрүүл орчинд ажиллах, амрах нөхцөл бүрдэнэ.

- ✓ Амьтан, ургамал, хөрс, усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл багасах зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Арьс шир, завод ноос боловсруулах төслийн үйл ажиллагаанаас хатуу, шингэн хог хаягдлыг ахуйн болон аюултай хог хаягдал хэмээн ялгаж тус бүрд нь тохирсон арга хэмжээг авч ажиллана.

Энгийн хог хаягдлын менежмент

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн талбайд Хог хаягдлын цэгийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17 өдрийн А/443 дугаар тушаалын хавсралт “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тэвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-ын дараах заалтын дагуу барьж байгуулан ашиглах шаардлагатай.



Зураг Хог хаягдлын цэгийн шийдэл

Төслийн талбайд байгуулах Хог хаягдлын цэгийг Зураг 2-д заасны дагуу битүүмжлэлтэй, цоожтой лист төмрөөр хийгдсэн байхаар хийх боломжтой ба хог хаягдлыг энгийн, дахивар, аюултай хог хаягдал зэрэг 3 ангилан ялгах нь зүйтэй.

Хүснэгт Ангиан ялгах хог хаягдлууд

Энгийн хог хаягдал	Дахивар хог хаягдал	Аюултай хог хаягдал
<ul style="list-style-type: none"> ✓ Хоолны үлдэгдэл; ✓ Хүнсний ногоо, жимсний хальс, үлдэгдэл; ✓ Яс; ✓ Хэрэглэсэн хүнсний тос ✓ Аюултай болон дахин боловсруулах хог хаягдлаас бусад хог хаягдал 	<ul style="list-style-type: none"> ✓ Цаас /хэт бохирдоогүй сонин, сэтгүүл, дэвтэр, бичгийн цаас, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, сүү, жүүсний тетрапак савлагаа/ ✓ Хуванцар /төрөл бүрийн ус, ундааны хуванцар сав, 0,025 мм-ээс дээш зузаантай гялгар уут, баглаа боодол кетчуп, ургамлын тос, бие угаагч шингэн, шампунь, угаалгын шингэний хуванцар сав, гм/ ✓ Хөнгөн цагаан, төмөр, метал, зэс, гууль, тэдгээрээр хийсэн зүйл; ✓ Шил /хүнсний болон бүх төрлийн шилэн сав, шилэн эдлэл/; ✓ Лааз; ✓ Мод, модон эдлэлийн хаягдал; 	<p>Аюултай хог хаягдал гэж амьтан, ургамлыг өвчлүүлэх, гэмтээх, тэдгээрийн үр удамд хор хөнөөл учруулах болон байгаль орчны хэвийн төлөв байдалд сөрөг нөлөөтэй хортой, идэмхий, исэлдүүлэгч, шатамхай, дэлбэрэх хог хаягдлыг хэлнэ.</p> <p>Иймд төслийн талбайн машин засварын цехийн үйл ажиллагаанаас гарч буй нефть болон газрын тосны бүтээгдэхүүн агуулж буй сав, савны цэвэрлэгэнд ашигласан цэвэрлэгээний материал, тос тосон бүтээгдэхүүн агуулж буй савны хаягдлыг энэ цэгт төвлөрүүлж Хог хаягдал</p>

	<ul style="list-style-type: none"> ✓ Хувцас, давуун эдлэл; ✓ Савхи, резин; ✓ Өвс, мод. 	тээвэрлэх машинд ачуулж тусгай цэгт хүргүүлнэ.
--	---	--

Хог хаягдлыг цуглуулахад тавигдах ерөнхий шаардлага

1. Энгийн хог хаягдлыг цуглуулах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.8-д заасныг ойлгох ба хуулийн 14 дүгээр зүйлд зааснаас гадна энэхүү тавигдах ерөнхий шаардлагын 2.3.2-2.3.5-д заасан ерөнхий шаардлага хамаарна.

2. Хог хаягдлын тухай хуулийн 14.2-т заасан гэрээнд хог хаягдал цуглуулах төрөл, хэлбэр, хогийн цэгийн байршил, ажиллах цагийн хуваарь, орчны тохижилт, ариун цэврийн шаардлагын талаар тодорхой тусгасан байна.

3. Хог хаягдлыг цуглуулах зориулалт бүхий сав, төхөөрөмж гэж энгийн хог хаягдлыг тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булилах зорилгоор хог хаягдлыг цуглуулж байгаа хог хаягдал үүсгэгчийн ойролцоо байршуулсан савыг хэлэх ба дараах ерөнхий шаардлага хангасан байна.

а. Хог хаягдал цуглуулах сав, төхөөрөмжийг сум, хорооны Засаг даргын зөвшөөрсөн хэлбэр, хэмжээ, зориулалт болон заасан газарт байгуулна.

б. Орон сууцны хороолол, нийтийн эзэмшлийн талбай, явган хүн, авто машины хөдөлгөөнд саад учруулахааргүй газар байна.

в. Хог хаягдал хийсэх, агаар болон хөрсөнд тархах, шингэх, уусах, үнэр тархахгүй нөхцөлийг бүрдүүлсэн байна.

г. Хог хаягдлын төрөл, ангиллын мэдээллийг ил харагдахуйц байршуулсан байна.

д. Байгаль орчинд сөргөөр үл нөлөөлөх нөхцөлөөр буюу чанарын шаардлага хангасан байна.

е. Тээвэрлэх зориулалт бүхий уяа, дэгээтэй, хог хаягдал ачих тээврийн хэрэгсэлд зориулагдсан байна.

ж. Хог хаягдал цуглуулах зориулалт бүхий сав, төхөөрөмжийн хог хаягдал хадгалах, цуглуулах багтаамж 3 хоногоос ихгүй байна.

4. Хог хаягдал цуглуулах иргэн, аж ахуй нэгж, байгууллагын ажилтан нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна.

а. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зохих мэдлэгтэй байх;

б. Хөдөлмөр хамгааллын нэг бүрийн хэрэгсэл хэрэглэх;

в. Хог хаягдал цуглуулах үйл ажиллагааны бүрэн мэдлэгтэй, хог хаягдал үүсгэгчийн онцлогийг тодорхойлох чадвартай байх.

5. Хог хаягдлын цуглуулахдаа ангилан ялгасан хог хаягдал тус бүрээр цуглуулна.

Аюултай болон хортой хог хаягдлын менежмент

Төслийн үе шатуудад машин засварын цехийн үйл ажиллагаанаас гарч буй нефть болон газрын тосны бүтээгдэхүүн агуулж буй сав, савны цэвэрлэгээнд ашигласан цэвэрлэгээний материал, тос тосон бүтээгдэхүүн агуулж буй савны хаягдал болон үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа химийн бодисын сав баглаа боодол зэрэг аюултай болон хортой хог хаягдал гарна. Иймд тус хог хаягдлын менежментийг дараах байдлаар зохицуулна.

✚ Химийн бодисын сав баглаа боодлыг, химийн бодисын сав баглаа боодол устгах эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллана.

- ✚ Үйлдвэрийн хог хаягдлыг Сонгинохайрхан дүүргийн “Тохижилт үйлчилгээний газар”-тай хог хаягдлын гэрээ байгуулан сумын хогийн цэгт тээвэрлэн аваачна.

Цаашид хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны явцад төсөл хэрэгжүүлэгч нь аль болох бага хог хаягдал үүсгэх, дахин ашиглах эсвэл дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг ялган ангилж савлаж хаях, үлдсэн хог хаягдлыг байгаль орчинд аюулгүй арга технологиор цуглуулах, хадгалах, ачуулах, тээвэрлэх, устгах зарчмыг баримтлан хог хаягдлыг зүй зохистой удирдан зохицуулахыг зорин ажиллах шаардлагатай байна. Үүний тулд:

- Ангилал тус бүр дэх хогийг цуглуулах, хадгалах, тээвэрлэх ба зайлуулах явцад үүсэх шинж чанарыг тодорхойлох,
- Хог хаягдлыг багасгах үр дүнтэй аргуудыг хэрэгжүүлэх, тухайлбал, арьс боловсруулах дамжлагаас гарч буй хогийг дахин ашиглах боломжийг судлах,
- Үүсэж буй бүх төрлийн хог хаягдлын зохицуулалт нь Монгол Улсын байгаль орчны хуулиуд ба стандартад нийцэх болно.

УЛААНБААТАР ХОТЫН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 4-Р ХОРООНЫ
НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИХ “ХАТАНСҮЙХ ИМПЭКС” ХХК-ИЙН “ХИАМ, МАХАН
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал /мян.төг/

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг өөрийн үйл ажиллагаанд тохируулан боловсруулж батлуулах, хэрэгжүүлж ажиллах.	Хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны тайлан				Хог хаягдлын тухай хууль, эрүүл ахуйн тухай хуулийн 4.4.3 зүйл, 13.1.6 зүйл, Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам
2	Хогийг ангилах ялгах, цэгийг сайжруулах, байнгын арчилгаа тордолт хийх, талбайн зонхилох салхины доод талд багтаамж сайтай хогийн сав байршуулах, ангилан ялгах тэмдэг тэмдэглэгээтэй болгох, ажилчид үйлчлүүлэгчид хог хаягдлаа ил задгай хаяхгүй байхыг анхааруулсан самбар, тэмдэг тэмдэглэгээ байршуулах.	Хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны тайлан	300.0	300.0	2023 онд	
3	Талбай болон ажлын байрыг тогтмол цэвэрлэж байх. Ажилчдыг цэвэрлэгээний бодис хэрэглэлээр байнга хангаж байх хэрэгтэй.	Хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны туршид	150.0	150.0	2023 онд	
2023 оны хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал						450.0	

5.8. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Төслийн хэрэгжилтийн үед авч хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын асуудал ихээхэн чухал үүрэгтэй юм. Удирдлага зохион байгуулалтын менежментийг дараах чиглэлд хандуулан төлөвлөгөөндөө тусгах нь зүйтэй.

- ✓ Байгаль орчны асуудал хариуцаж ажиллах ажилтан албан хаагч, түүний үүрэг хариуцлага
- ✓ Байгаль орчны чиглэлээр орон нутгийн иргэд, олон нийттэй хамтран ажиллах ажлын чиглэл
- ✓ Ажилтан албан хаагчдын дунд зохион байгуулах сургалт, танилцуулгын ажил, мэдээллийн самбар
- ✓ Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр хийгдэх ажил
- ✓ Байгаль орчин хамгааллын чиглэлээр хийгдэх хяналт, шалгалтын хуваарь, бүртгэл хөтлөх, түүнийг хариуцах үүрэг хариуцлагын систем
- ✓ Байгаль орчин хамгааллын чиглэлээр бусад байгууллагатай хамтран ажиллах ажлын төлөвлөгөө, хуваарь
- ✓ Байгаль орчин хамгааллын чиглэлээр хийгдэх ажлын төсөв санхүүгийн зохицуулалт
- ✓ Эдгээр ажлуудыг хариуцан гүйцэтгэх байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах

Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр: Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллах, жилийн эцэст БОМТ-ний хэрэгжилтийг Нийслэлийн БОГ-аар дүгнүүлэх, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, байгаль орчны хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор компанийнхаа дотоод дүрэм, журамд өөрчлөлт оруулах, Онцгой байдлын газар /ОБГ/, Мэргэжлийн хяналтын газар /МХГ/ зэрэг байгууллагуудаар станцын үйл ажиллагаанд хяналт тавиулж, хамтран ажилчдынхаа дунд галын аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын сургалтуудыг зохион байгуулах, осол эрсдэлээс хамгаалах ажлыг зохион байгуулах шаардлагатай.

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах ажлууд:

Төслийн ажилчид, албан хаагчдыг үр бүтээлтэй, осол авааргүй ажиллуулах тулд Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга хэмжээг цаг тухай төлөвлөн, ажиллагсдад улирал бүр зааварчилгаа өгүүлэх, үе шаттайгаар хянан шалгах арга хэмжээнүүдийг өөртөө багтаасан Компанийн Хөдөлмөр Хамгаалал, Аюулгүй Ажиллагааны (ХХАА) системийг бий болгож түүн дээр үндэслэн, олон улсын болон Монгол улсын холбогдох хууль тогтоомжуудын шаардлагуудад нийцсэн журам стандартуудыг харьяалагдах байгууллагуудтай хамтран боловсруулж, батлуулан (Монгол улсын засгийн газраас 2005 онд баталсан ХХАА, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөрийн 2.1.4, 2.1.6 заалтад тулгуурлан) мөрдөж ажиллах нь төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг юм.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр ажилчдад ажлын байрны онцлог тус бүрд нийцсэн ажлын хувцас хэрэгслийг олгох, хортой нөхцөлд ажилладаг ажилтанд хор саармагжуулах бүтээгдэхүүнийг ажлын байранд тогтмол олгох, жил бүр эрүүл мэндийн төвтэй хамтран нийт ажиллагсадаа эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулан, нарийн мэргэжлийн эмч нараар ажил, мэргэжлийн онцлогоос шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, зөвлөгөө өгүүлэх, шаардлагатай тохиолдолд ажилтнуудыг амбулаториор эмчилгээнд хамруулах, машин тоног төхөөрөмж дээр ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг байрлуулж, ажилд гарахын өмнө ажиллагсадад аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгөх, ажлын байранд яаралтай үед хэрэглэх түргэн тусламжийн багаж хэрэгсэл, эм тариа бэлтгэх ажлуудыг төлөвлөжээ.

Хүснэгт Байгаль орчны менежментийн хүрээнд хэрэгжүүлэх ажил

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг	Хариуцагч
1	Байгаль орчныг хамгаалах, осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 2 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	2023 онд	Дотоод зохион байгуулалтаар	Төсөл хэрэгжүүлэгч
2	Байгаль хамгаалах талаар хийх ажлын төлөвлөгөө (тухайн жилийн БОМТ)-г БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газарт, хийсэн ажлын тайланг (биелэлтийн тайлан) нийслэлийн байгаль орчны газарт хүргэн өгч, хянуулах, батлуулан хэрэгжүүлэх	Жил бүрийн 12 сард	Дотоод зохион байгуулалтаар	
	Үйлдвэрийн хаягдал бохир усыг MNS 6561:2015 стандартад нийцүүлж төвлөрсөн шугамд нийлүүлэх биологийн цэвэрлэх байгууламжтай болох	2023 онд	Дотоод зохион байгуулалтаар	
3	Байгаль хамгаалахад хороо, дүүргийн холбогдох ажилтнуудын оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-нд тусгах	2023 онд	-	
Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал			-	

Хүснэгт Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Хийгдэх ажил	Хугацаа	Зардал, мян.төг	Хариуцах ажилтан
1	Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах сургалт зохион байгуулах, галын аюулгүй ажиллагааны талаар аймгийн ГТХХЭлтэстэй хамтран галын аюулаас урьдчилан сэргийлэх үзүүлэх сургууль хийх	3-р улирал	-	Төсөл хэрэгжүүлэгч
2	ХХААЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах	Улирал бүр	Дотоод төлөвлөлтөөр	Төсөл хэрэгжүүлэгч
3	Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах хэрэгсэл, амны хаалт, малгай зэргээр хангах	жилдээ	Дотоод төлөвлөлтөөр	Нярав
4	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд зарцуулах зардал	жилдээ	600.0	Төсөл хэрэгжүүлэгч
5	Ажилчдын эрүүл мэндэд хор хөнөөл учрахаас сэргийлэн тэжээллэг, хордлого тайлах хоол хүнс, тухайлбал сүү, аарц, гүүний саам зэргээр хангах зардал	Өдөр бүр	Дотоод төлөвлөлтөөр	Төсөл хэрэгжүүлэгч
Нийт дүн			600.0	

5.8.1. Байгаль орчны төлөвлөгөөт аудитын зардал

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А-126 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 2.1-д **“Төлөвлөгөөт аудитыг хоёр жил тутамд, төлөвлөгөөт бус аудитыг Засаг дарга, эсхүл байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аудит хийлгэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хийнэ”** хэмээн заасны дагуу аж ахуйн нэгж өөрийн зардлаар аудит хийлгэнэ.

Хүснэгт 3. Байгаль орчны төлөвлөгөөт аудитын зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, сая.төг	Хариуцагч
	“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 101 дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд төслийн үйл ажиллагаанд хийлгэх	2023 оны 3-р улиралд	3 000.0	Төсөл хэрэгжүүлэгч
			2 000.0	

5.9. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

БОХТ-тэй холбогдон удирдамж болох үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлэн, “ХАТАНСҮЙХ ИМПЕКС” ХХК-ний хэрэгжүүлэх ОХШХ боловсруулав.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, төсөл хэрэгжих орчинд амьдардаг, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн амьжиргаа, нийгмийн болон эрүүл мэндийн байдлыг илтгэх гол үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамж зэргийг бүхэлд нь тусгасан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний чухал хэсэг юм.

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт дараах зүйлсийг тусгадаг. Үүнд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрд үзүүлэх нөлөөлөл, хяналт-шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай үзүүлэлтүүд, төрөл, хэлбэр;
- Хяналт-шинжилгээ хийх, сорьц авах цэгийн байршил, хугацаа, давтамж;
- Хяналт-шинжилгээ хийх арга, аргачлал, түүнд шаардлагатай техник, тоног төхөөрөмж;
- Хяналт-шинжилгээний үр дүнг нэгтгэх, тайлагнах арга, хэлбэр зэрэг болно.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг төсөл хэрэгжүүлэгч хариуцна.

Хүснэгт Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Бүрэлдэхүүн хэсэг	Дээж авах цэг	Мониторинг хийх үзүүлэлтүүд	Давтамж	Зардал, мян.төг	2023 ОНД хугацаан дахь нийт зардал	Тайлан	Баримтлах стандарт ба аргачлал
Агаарын чанар	Үйлдвэрийн дотоод орчинд	<ul style="list-style-type: none"> Тоосжилт (PM₁₀, PSM, PM_{2.5}) Гадаад болон дотоод орчны дуу чимээ, доргио, чичиргээ Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд (тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг, чийгшил болон физик бохирдлын түвшин) 	Жилд 2 удаа	200.0	200.0	Биелэлтийн тайланд үр дүнг тодорхойлж, нийслэлийн Байгаль орчны газарт хянуулах	<ul style="list-style-type: none"> MNS3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага MNS0017-2-3-16:1988. Агаар мандал-Хот суурины агаарын бохирдлын шинжилгээ MNS3384:1982. Агаар мандал-Агаарын дээжлэлт шинжилгээ MNS0012-014:1991. Ажлын байрны агаар-Бичил орчныг шинжлэх арга MNS0012-1-015:1987. Чимээ шуугиан-Ажлын байрны чимээ шуугианыг хэмжих арга
	Үйлдвэрийн хашаанд						
Усны чанар	Ашиглаж буй усны эх үүсвэрээс	Натри Na ⁺ , Кали, K ⁺ , Кальци Ca ²⁺ , Магни Мд ²⁺ , Сульфат SO ₄ ²⁻ мг/л, Гидрокарбонат HCO ₃ , Карбонат CO ₃ ²⁻ , Хлорид, С1мг/л, Амт, Өнгө, Үнэр, Рн, Цахилгаан дамжуулах чанар, Хатуулаг, Аммони (NH ⁴⁺), Нитрат (NO ₃ ⁻), Нитрит (NO ₂), Умбуур бодис TSS, Химийн хэрэгцээт хүчилтөрөгч	Улиралд нэг удаа	50.0	400.0		<ul style="list-style-type: none"> MNS0900:1992. Ундны ус-Ундны усны хяналт-шинжилгээ MNS3935:1986. Ундны ус-Усны шинжилгээнд тавигдах шаардлага MNS3936:1986. Ундны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт шинжилгээ хийх MNS3934:1986. Ундны болон үйлдвэрийн ус-Химийн шинжилгээ хийх-Дээж авах, хадгалах, зөөвөрлөх
	Үйлдвэрээс гарч буй бохир усанд			100.0	400.0		
Хөрсний чанар	Үйлдвэрийн урд талын ногоон байгууламжтай талбайгаас	Al*, Ca, Mg, K, Fe _{нийт} , As, Ba*, Be, Bi, Cd, Co, Cr, Cu, La, Li, Mn, Mo, Ni, P, Pb, Sb, Se, Sr*, Ti, V, Y, Zn, Zr*	Жилд 2 удаа	50.0	100.0	<ul style="list-style-type: none"> MNS5850:-2008. Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS2305-94. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам 	
Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал урьдчилсан байдлаар / 2023 он/							1 100.0

Төслийн байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт зардал, түүний хуваарилалтыг Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж өгсөн ба жил бүр шинэчлэн тооцож байх шаардлагатай болно.

5.10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх мөн төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн хорооны иргэдийн нийтийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ.

Хүснэгт 4. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Нийслэлийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	Тухайн жилийн БОМТ хүргүүлэн батлуулна.	БОМТ болон хэрэгжилтийн явцаас төслийн үйл ажиллагаа, байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг агуулсан байна.	Жил бүр 12-р сарын дотор зардлын асуудлыг доор дурдав.	Өмнөх оны БОМТ хэрэгжилтийг хүлээн авч дүгнэх, дараа жилийн төлөвлөгөөг хянан батлах ажлын 21 хоногт багтааж шийдвэрлэнэ. Дүгнэлт авна.	Тухайн жилийн БОМТ хэрэгжилттэй холбогдсон хариуцлагыг төсөл хэрэгжүүлэгч бүрэн хариуцна. Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн БОМТ боловсруулахдаа байгаль орчны нөлөөллийн үнэлгээний эрх бүхий мэргэжлийн байгууллагаас мэргэжил, арга зүйн туслалцаа авч болно.
Нийслэлийн БО-ны албадууд	БО-ны аудитын тайлан	Тухайн төслийн байгаль орчны талаарх авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний нийцэл, үл нийцлийн талаарх зөвлөмжүүдийг агуулсан байна.	2 жил тутам, удирдан зохион байгуулах хэсэгт тусгасан	Дүгнэлт зөвлөмж гарна.	Байгаль орчны аудит хийх эрх бүхий компани, аж ахуйн нэгжээр тайланг хийлгэнэ.
Оролцогч талууд байгууллагууд	Мэдээллийн сан үүсгэх	Бүх төрлийн зөвшөөрөл, тайлан, шинжилгээний хариу, өгөгдлүүдийг өгөгдлийн сан үүсгэн хадгалж байх шаардлагатай	Яаралтай эхлүүлэх. Үйл ажиллагааны зардлаас	Өгөгдлийн санг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж болно.	Төсөл хэрэгжүүлэгч
Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүргийн 4-р хороонд үйл ажиллагаа явуулж буй Хиама, махан бүтээгдэхүүний үйлдвэр нь жил бүр БОМТ-ний дагуух хэрэгжилтийг хангасан тухай болон дараа жилийн төлөвлөгөөний тайланг бэлтгэн нийслэлийн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, тайлагнаж батлуулах үүрэг хүлээнэ. Тухайн салбарын байгаль орчин, аюулгүй байдал, эрүүл ахуйн инженерийн цалин болон удирдлага зохион байгуулалтын зардлаар тодорхойлогдоно.					

БҮЛЭГ 6. ХУУЛЬ ТОГТООМЖ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Төслийн хэрэгжилтийн үед мөрдөж ажиллах Монгол Улсын хуулиуд, Монгол улс нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр, протокол, түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, үндэсний хөтөлбөр, байгаль орчны журам дүрэм, стандарт, аргачлал, судалгаа шинжилгээ, техникийн даалгавар, бусад холбогдох материалуудыг доор тусгав.

Хүснэгт Монгол Улсын хууль тогтоомж

№	Хуулийн нэр	Хуулийн хамрах хүрээ
Монгол улсын хуулиуд		
1	Монгол улсын үндсэн хууль, УИХ, 1992.02.12	
Байгаль орчныг хамгаалах ерөнхий болон салбар хуулиуд		
2	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, УИХ, 2008.01.31	Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зүй зохистой ашиглах зэрэг төслийн хэрэгжилтийн бүхий л үе шатанд энэхүү хуулийг барьж ажиллана.
3	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай /Шинэчилсэн найруулга/, УИХ, 2012.05.17	Төслийн хэрэгжилтийн хугацаанд байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээг тогтоож ажиллана.
4	Агаарын тухай /Шинэчилсэн найруулга/, УИХ, 2012.05.17	Төслийн хэрэгжилтийн хугацаанд агаарыг хамгаалах, бохирдохоос сэргийлэх, агаар бохирдуулах бодисын хаягдлыг бууруулж хяналт тавихад хуулийг барьж ажиллана.
5	Амьтны тухай /Шинэчилсэн найруулга/, УИХ, 2012.05.17	Төслийн үйл ажиллагааны бүхий л үе шатанд амьтны аймгийг хамгаалах, төрөл зүйлийг устахаас сэргийлэх, чиглэлээр анхаарч, энэхүү хуулийг барьж ажиллана.
6	Усны тухай /Шинэчилсэн найруулга/, УИХ, 2012.05.17	Төслийн хэрэгжилтийн бүхий л үе шатанд усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, зохистой ашиглахад энэхүү хуулийг барьж ажиллана.
7	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, УИХ, 1997.11.13	Төслийн хэрэгжилтийн бүхий л үе шатанд ус цаг уурын мэдээг урьдчилан авч, үйл ажиллагаанд байгаль цаг уурын хүчин зүйлээс шалтгаалах осол аюулаас урьдчилан сэргийлж ажиллахад энэхүү хуулийг барьж ажиллана.
8	Ургамал хамгааллын тухай, УИХ, 2007. 05.17	Бүхий л үе шатанд ургамлын төрөл зүйлийг хамгаалан ажиллах
9	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай, УИХ, 2012.05.17	Төслийн үйл ажиллагааны үе шатанд анхааран ажиллах
Эрчим хүчний тухай хуулиуд		
10	Эрчим хүчний хэмнэлтийн тухай, УИХ, 2015.11.26	Эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.
11	Сэргээгдэх эрчим хүчний тухай, УИХ, 2007.01.11	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах эрчим хүч үйлдвэрлэх, нийлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиуд		
11	Агаарын бохирдлын төлбөрийн тухай, УИХ, 2010.06.24	Станцын техник тоног төхөөрөмжөөс гарах бохирдуулагч бодисоос агаар бохирдуулсны төлбөрийг төлөх харилцааг зохицуулна.
12	Ус ашигласны төлбөрийн тухай, УИХ, 2008.12.19	Үйлдвэрт ашиглах усны төлбөрийг төлөх харилцаанд энэхүү хуулийг барьж ажиллана. /Гэрээ хийсэн компанитай харилцан шийдвэрлэнэ/
13	Ус бохирдуулсны төлбөрийн тухай, УИХ, 2012.05.17	Үйл ажиллагаанаас ус бохирдуулсан тохиолдолд төлбөр төлөх харилцаанд энэхүү хуулийг барьж ажиллана.
Бусад хуулиуд		
14	Галын аюулгүй байдлын тухай, УИХ, 1999.05.28	Бүхий л үе шатанд галын аюулгүй байдлыг хангахад холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү хуулийг барьж ажиллана.
15	Гамшгаас хамгаалах тухай, УИХ,	Гамшгаас хамгаалах асуудлаар хүлээх үүргийг хэрэгжүүлэхтэй

	2003.06.20	холбогдсон харилцааг зохицуулна. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгоход, уялдуулан зохицуулахад энэхүү хуулийг барьж ажиллана.
16	Химийн хорт болон аюултай бодисын тухай, УИХ, 2006.05.25	Химийн бодис, шатах тослох материалыг ашиглахад энэхүү хуулийг барьж ажиллана.
17	Эрүүл мэндийн тухай, УИХ, 2011.05.05	Ажиллагсад эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахад холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү хуулийг барьж ажиллана.
18	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, УИХ, 2008.05.22	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хяналтын тогтолцоо, ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү хуулийг барьж ажиллана.
19	Хөдөлмөрийн тухай, УИХ, 1999.05.14	Ажлын байраар хангах тохиолдолд хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг, хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн ганцаарчилсан ба хамтын маргаан, хөдөлмөрийн нөхцөл, удирдлага, хяналт болон хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж талуудын харилцан эрх тэгш байдлыг хангахад хуулийг барьж ажиллана.
20	Хог хаягдлын тухай, УИХ, 2012.05.17	Төслийн хэрэгжилтийн үед хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгахад холбогдсон харилцааг зохицуулахад хуулийг барьж ажиллана.

Хүснэгт Монгол улсын байгаль орчны чанарын норм стандарт

№	Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартууд
2	MNS 5919:2008 Дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын ба ус халаах зуухны ашиглалтын үед агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих арга.
1	MNS (ISO) 5667-1:2002 Усны чанар. Дээжлэлт. Хэсэг 1. Дээжлэлтийн хөтөлбөр боловсруулах удирдамж.
2	MNS 900:2018 Байгаль орчин. Хүний эрүүл мэндийн хамгаалалт. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлагууд болон чанарын хяналт.
3	MNS 4586:1998 Усны хүрээлэн буй орчны чанар. Ерөнхий шаардлагууд.
4	MNS 2573:1978 Байгаль орчныг хамгаалах. Усан мандал. Усны чанарын үзүүлэлтүүд.
5	MNS 3935:1986 Ундны ус. Усыг газар дээр нь шинжлэх ерөнхий шаардлагууд.
6	MNS 3936:1986 Ундны ус. Усыг газар дээр нь шинжлэх аргууд.
7	MNS 3900:1986 Ундны ус. Усны амт, өнгө, үнэр ба булинганыг тодорхойлох.
8	MNS 3342:1982 Гүний усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлагууд.
9	MNS 6148:2010 Усны чанар. Гүний усны бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх агууламж.
10	MNS 0017-1-1-10:1979 Ус ашиглалт ба хамгаалалт. Нэр томьёо, тодорхойлолт.
11	MNS 2570:1978 Усны ариун цэврийн чанарыг тодорхойлох арга.
12	MNS 4079:1988 Усны чанарын нэр томьёо ба тодорхойлолт.
13	MNS (ISO) 10523:2001 Усны чанар. Рн тодорхойлох.
14	MNS 3384:1982 Агаар мандал. Дээжлэлтэд тавигдах ерөнхий шаардлагууд.
15	MNS 3383:1982 Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр. Нэр томьёо, тодорхойлолт.
16	MNS 5885:2008 Агаар бохирдуулагч бодисуудын зөвшөөрөгдөх агууламж
17	MNS (ISO) 4225:2001 Агаарын чанар. Ерөнхий оршил. Үг хэллэг.
18	MNS 5365:2004. Агаарын чанарын ерөнхий асуудлууд. Нарийн ширхэгтэй тоосонцрыг тодорхойлох арга.
19	MNS 4219:2002 Агаарын чанар. Орчны агаар дахь хүхрийн агууламжийг тодорхойлох.
20	MNS 4585: Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлагууд.
21	MNS 5914:2008 Байгаль орчин. Газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт.
22	MNS 4920:2000 Байгаль орчин. Эвдрэлд орсон газрын налуу. Техникийн шаардлагууд.

23	MNS 3298:1991 Хөрс. Дээжлэлтийн ерөнхий шаардлагууд.
24	MNS 3297:1991 Хөрс. Эрүүл ахуйн үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ.
25	MNS 4969: 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтын зохион байгуулалт, үндсэн зарчим
26	MNS 5010:2001 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага
27	MNS 5029:2001 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт бодисын шошго, тэмдэглэгээ
28	MNS 5078:2001 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавигдах шаардлага
29	MNS 5079:2001 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Ачих буулгах үеийн аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
30	MNS 5080:2001 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ
31	MNS 5105:2001 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага
32	MNS 5107:2001 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Биеийн хүчний ажлын ачааллыг үнэлэх үзүүлэлтийн норм тодорхойлох
33	MNS ILO-OSH 1:2003 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Удирдлагын тогтолцооны талаарх удирдамж
34	MNS 0012-4-002:1985 Дохионы өнгө. Аюулгүй ажиллагааны тэмдэг
35	MNS 4643:1998 Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны тэмдэг ба дохионы өнгө
36	MNS 5622:2006 Гарын хамгаалалт. Бээлий

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал. 2014.
- Химийн хорт болон аюултай бодисын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал, Улаанбаатар хот, 2012 он
- *Д.Доржготов*. Монгол орны хөрс. УБ. 2003.
- *Д.Доржготов*. Монгол орны хөрс-газарзүйн мужлалд. УБ. 1974
- *Д.Даваадорж*. Монгол улсад бүртгэгдсэн химийн бодисуудын аюулын үнэлгээ химийн аюулын лавлах мэдээлэл, УБ. 2010.
- *Д.Аваадорж*. Хээрийн туршлагын арга зүйн үндэс. УБ. 2004.
- *Д.Аваадорж, С.Бадрах, О.Хадбаатар*. Бэлчээрийн ургамалжилтын өөрчлөлт, экологийн доройтол. Монгол орны геоэкологийн асуудал. УБ. 2003.
- *Ц.Алтанзул, С.Цэрэндаш, Л.Лхагважав*. “Бэлчээр судлал 50 жилд” УБ. 2011.
- *Воронов А.Г.* Геоботаника. М. 1965г.
- *Грубов.В.И.* Конспект флоры Монгольской Народной Республики. М 1955, 1963, 1972, 1982 г
- *С.Жигжидсүрэн*. Бэлчээрийн менежмент. УБ. 2005.
- *С.Жигжидсүрэн*. Монгол орны хотгор гүдгэрийн үндсэн шинж. УБ. 1975.
- *Н.Манибазар*. Ургамлын дүймэн. УБ. 2000.
- *Д.Цэгмэд*. Монгол орны физик газарзүй, Улаанбаатар 1968 он. Хуу 306-325.
- *Kh.Terbish, Kh.Munkhbayar, M.Munkhbaatar*. A Guide to the amphibians and reptiles of Mongolia. UB 2006. P 21-60.
- *Ш.Болдбаатар*. Монгол орны шувууны фото лавлах. УБ. 2008он. Хуудас7
- *Н.Цэвээнмядаг, Б.Нямбаяр, Ц.Мөнхзул*, Монгол орны түгээмэл шувуудыг таних ном. УБ. 2010он. Хуу-126,127,128,142, 110, 104, 47, 66, 120
- Монгол орны гадаргын ус ном, УБ. 2000.
- Уур амьсгал, гадаргын усны нөөцийн атлас, УБ.,
- Монгол улсын үндэсний атлас, 1990.
- <https://www.epa.gov/iris>
- http://www.eic.mn/envmonitor/index_mn.php
- <http://phi.gov.mn/files/2015/06/888c8872-2882-4489-8f10-1eca6d22a1cc.pdf>
- <http://greenassessment.mn/>
- Монгол орны хөрсний зураг. М1:3000 0000 масштаб
- Монгол улсын үндэсний атлас. 1986, 2009 он. УБ
- Ландсатын зураг (Landsat, Quick bird) 2005-2010он
- Google Earth, Quick bird-ийг зураг 2008-2010 он
- Кормоботаническая карта МНР, (1: 1000000) 1981.
- Стандартууд



УЛААНБААТАР ХОТЫН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 4-Р ХОРООНЫ
НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИХ “ХАТАНСҮЙХ ИМПЭКС” ХХК-ИЙН “ХИАМ, МАХАН
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭР”ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

Хуульчилсан үйлдвэр / ХХК / 2016 он 12 сар 2 өдөр

ХТЭМ / Хуульчилсан үйлдвэр /



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭГТЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
 601110111

2006 03 14 / Хуульчилсан үйлдвэр /

9011040112 / Хуульчилсан үйлдвэр /

2058118 / Хуульчилсан үйлдвэр /

Хатагт Хатагсүйх Импэкс / Хятагт Хатагсүйх Импэкс /

Хятагт Хатагсүйх Импэкс / Хятагт Хатагсүйх Импэкс /

Дүрэм
/ Хуульчилсан үйлдвэр /

Тогтоол 1 1996 03 27
/ Хуульчилсан үйлдвэр / / Хуульчилсан үйлдвэр / / 1996 он 3 сар 27 өдөр /

1010 / Хуульчилсан үйлдвэр /

1001 / Хуульчилсан үйлдвэр /

4121 / Хуульчилсан үйлдвэр /

5010 / Хуульчилсан үйлдвэр /

6010 / Хуульчилсан үйлдвэр /

1000 / Хуульчилсан үйлдвэр /

1001 / Хуульчилсан үйлдвэр /

1001 / Хуульчилсан үйлдвэр /

Хугацаагүй 1 2 795 449 20
/ Хуульчилсан үйлдвэр / / Хуульчилсан үйлдвэр / / Хуульчилсан үйлдвэр /

Улаанбаатар, Сонгинохайрхан 4-р хороо, 10-Хатагсүйх Импэкс ХХК-ий байр, утас: 70112487, факс: 70111627
/ Хуульчилсан үйлдвэр /

Оюуны өмч, улсын бургалийн өрөөний газрын Хуулийн этгэдийн бүртгэлийн хуульчилсан үйлдвэр / Хуульчилсан үйлдвэр /

Гэрчилгээ өгөх өдөр 2016 он 12 сар 2 өдөр

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийн бүртгэл


Д.д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ижилтэй тэмдэг
1	Мажит Басалтай, Батсайхансүх Ганзориг, Энхбаяр Лхамсүх-а бүртгэв	2014.10.10	
2	Данхын Эсрэгчигэлэв	2016.12.02	
3	Сандангийн Сандан, Сандангийн Сандан, Энхбаяр Лхамсүх бүртгэв	2019.05.01	



АЖ АХУЙН НЭГЭЖ Хатаан сүйх импекс ХХК (2088118) -н ЭЗЭМШИЖ БАЙГАА
 ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

ХААР УНДЭВЭРЭГЭЙН ДУРАГ 1863531005287
 ХААР УНДЭВЭРЭГЭЙН ДУРАГ 1863531005287
 Цэвэр хэвцэн барилдагд, 2012.10.16 ИИГА-ны 2015.4.17-ны 2/12331 тоолоор эрх тусгалауулагдсан тоот хаатга

№	X	Y	срэгүүд урт
1	31022111	6356330	1.2
2	31022114	6356332	2.8
3	31022122	6356333	3.8
4	31022133	6356334	4.1



Талбайн хэмжээ : 4328 квадрат метр
 Зураг үндсэн (Б.Ариунбат)
 (НЭХГ-ийн кадастрын хэлтсийн мэргэжилт
 (Тамга)Хянасан (Б.Зардамбал)
 (Кадастрын хэлтсийн дарга)

Зургийн масштаб 1:1000 (1 см=10 метр байгана)

МОНГОЛ УЛАМ
ЗӨРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

ЗӨРҮҮЛ МЭНДИЙН ЧИГААГААР АЗОРГЭЖЛИЙН
ҮЙЛ АЖИЛААГААА ЗӨНХАЭХ ТУСТАЙ ЭЗЭВШИГЭЭНЭЭ

0002862

ГЭРЧИЛГЭЭ CERTIFICATE

Огноо: 2017 оны 06 сар 15 өдөр
Дугаар: АХ-17/23/3627

Бичүүлэгч: “АДХИМИ СЕЛИС КЛЕН ФЕРПЕКТ” ХХК

Үйл ажиллагааны төрөл: Ахуйн шарьж, мөргөч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх
Бодис импортлох, ханган нийлүүлэх

Үйл ажиллагааг зохицуулах зүйлс: Улсын хэмжээнд

Бичүүлэгчийн мөхөн зөвшөөрлийн дугаар: Бичээгч дүүрэг, 25-р хороо, 13-р хороолол,
97/2 байр

Урсгал бүртгэлийн гэрчилгээний дугаар: №9011088081 РД-5120772

Гаднахан мөхөн зөвшөөрлийн ажлуудын мөхөн зөвшөөрлийн гэрчилгээний дугаар:

Гэрээний огцролын өдөр: 2020 оны 06 сар 15 өдөр

КОМИССИЙН ДАРГА: Г.БЯМБАСҮРЭН



X БАТЛАВ "МАХ ИМПЭКС" ХХК-ийн БАТЛАВ "ХАТАНСҮЙХ ИМПЭКС" ХХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г. БУДРАГЧААГ

Менежментийн гэрээ

2017 оны 08 дугаар сар 01

№ 50

Улаанбаатар хот

Нэг талаас Сонгинохайрхан дүүрэг 4 дүгээр хороо, Хүнсчдийн гудамж, өөрийн
баиранд орших "Мах Импэкс" ХК (РД: 2069229) /цаашид "Үйлчлэгч" гэх/, түүнийг төлөөлж
албан тушаалтай овогтой Нөгөө талаас
СХД-р хотоо Менежментийн гэрээг хаягт орших
"ХатаНСүйх ИмПэкс" ХК, ХХК (РД: 2069229) /цаашид "Үйлчлүүлэгч" гэнэ /, түүнийг
төлөөлж Гүйцэтгэх захирал албан тушаалтай /цаашид / овогтой /
хамтад нь талууд гэх/ бид дор дурдсан гэрээг байгуулав Үүнд:

1. Гэрээний зүйл

- 1.1 Үйлчлэгч нь үйлчлүүлэгчид өөрийн өмчийн цахилгаан, цэвэр бохир ус уурын шугам сүлжээ тоног төхөөрөмжийг ашиглуулах, мөн үйл ажиллагаа явуулж буй байрны гадна талбайн харуул хамгаалалт аюулгүй байдлыг хангах үйлчилгээг үзүүлнэ.
- 1.2 Талууд энэхүү гэрээнд Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэв

2. Гэрээний хугацаа

- 2.1 Энэхүү гэрээ нь 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр бөгөөд гэрээний хугацаа дуусахад талууд ямар нэгэн санал гаргаагүй бол анх байгуулагдсан хугацаагаар дахин сунгагдана.
- 2.2 Гэрээний биелэлтийг талууд улирал бүр дүгнэж шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Тус нэмэлт нь гэрээний нэгэн хэсэг болно.

3. Төлбөр тооцоо

- 3.1 Үйлчлүүлэгч компани хэрэглэсэн цахилгаан эрчим хүч, бохир ус ашиглалтын төлбөрийг тоолуурын заалтаар, халаалтын төлбөрийг Монгол улсад мөрдөж буй тарифаар, цахилгаан эрчим хүч цэвэр бохир ус, халаалтыг түгээхэд гардаг зардал, байгууллагын түгээлтийн зардал зам талбайн ашиглалт, хамгаалалтын зардлын хамтаар эрхэлсэн захиргааны байгууллагын тогтоосон үнээр тооцоолон үйлчлэгч компанид төлнө.
- 3.2 Цахилгаан эрчим хүч, цэвэр бохир ус, халаалт, уурыг түгээхэд гарах зардлыг дараахь байдлаар тооцно.

- 1) Цахилгаан эрчим хүч 1 квт тутамд 06-17 цагийн хооронд 15 төгрөг, 17-22 цагийн хооронд 15 78 мөнгө, 22-06 цагийн хооронд 15 53 мөнгө ✓
- 2) Цэвэр ус 1 м.куб тутамд 240 төгрөг
- 3) Бохир ус 1 м.куб тутамд 134 төгрөг
- 4) Халаалт 1 м.куб тутамд 134 төгрөг
- 3.3 Үйлчлүүлэгч компани нь байгууламжийн хэвийн үйл ажиллагааг хангахад зориулагдах цахилгааны суурь 100,000 төгрөг, цэвэр усны суурь хураамж 100,000 төгрөг, бохир усны суурь хураамж 200,000 төгрөг, Уурын шугам ашигласны төлбөр 400,000 төгрөг, Хог хаягдлын төлбөр 200,000 төгрөг, Харуул хамгаалалтын зардал 600,000 төгрөг, зам талбай ашиглалтын төлбөр 200,000 төгрөгийн төлбөрийг сар нэмж төлнө.
- 3.4 Үйлчлэгч нь үйлчлүүлэгчийн зохих төлбөрийн нэхэмжлэлийг сар бүрийн 30-ний өдөр гаргаж өгнө
- 3.5 Үйлчлэгчийн гаргаж өгсөн нэхэмжлэлийн дагуу үйлчлүүлэгч нь сар бүрийн 5-ны өдөр төлбөр тооцоог барагдуулсан байна.
- 3.6 Тус гэрээний хугацаанд төрийн захиргааны байгууллагаас тогтоосон цахилгаан, ус, халаалтын үнэ өөрчлөгдсөн тохиолдолд талууд тохиролцон мөн үнийн өөрчлөлтийг гэрээний хавсралтаар оруулна.

4. Үйлчлэгч байгууллагын эрх, үүрэг

- 4.1 Үйлчлүүлэгч компани нь үйлчлүүлэгчийн үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцөл бололцоогоор ханган цахилгаан, цэвэр бохир ус, халаалт, хамгаалалтыг тогтвортой хангаж ажиллана.
- 4.2 Үйлчлүүлэгчийн өгсөн жагсаалтын дагуу нэвтрэх үнэмлэхийг үндэслэн ажилчид болон тээврийн хэрэгслийг байгууллага руу чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.
- 4.3 Үйлчлэгч компани нь үйлчлүүлэгчийн захиалсан эрчим хүчийг өөрийн ... дугаар дэд станцын ... дугаар гаргалгаан дээр суурилагдсан ... дугаар тоолууртай шугамаар дамжуулана.
- 4.4 Үйлчлэгч компани нь өөрийн эзэмшлийн шугам цахилгаан сантехникийн тоноглолд засвар үйлчилгээ өөрчлөлт хийх зорилгоор цахилгаан ус таслах шаардлага гарсан тохиолдолд нэг хоногийн өмнө, яаралтай засвар үйлчилгээ шаардлагатай болсон тохиолдолд нэн даруй утсаар болон өөрийн биеэр мэдэгдэх үүрэгтэй.
- 4.5 Цахилгаан усны тоолуур эвдэрсэн бол үйлчлүүлэгч нь өмнөх сарын дундажаар тооцон төлбөрөө төлнө.
- 4.6 Үйлчлэгч тал нь аливаа эрсэдлээс урьдчилан сэргийлэх үүднээс сар бүр 2 удаа үзлэг шалгалт хийх эрхтэй.
- 4.7 Байгалын гамшиг, үер усны аюул, цахилгаан хязгаарлалт, шугам сүлжээний аваар осол, урьдчилан мэдэх боломжгүй давагдашгүй хүчин зүйл болсон үед үйлчлүүлэгч талд учирсан хохирлыг хариуцахгүй.
- 4.8 Үйлчлэгч нь өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, халаалт арматур, дэд бүтцийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг шалгах, засвар үйлчилгээ хийх зорилгоор үйлчлүүлэгч байгууллагын байранд нэвтрэх зөрчил дутагдал илэрвэл арилгуулахаар шаардлага тавих эрхтэй.
- 4.9 Үйлчлэгч компани нь үйлчлүүлэгчээс төлбөр тооцоогоо өгөхийг шаардах хэрвээ

Үйлчлүүлэгч
 тооцоог сар
 бүр 2
 удаа
 үзлэг
 шалгах
 эрхтэй

- өлөөгүй хугацаа хэтрүүлсэн тохиолдолд үйлчилгээ үзүүлэхээ зогсоох эрхтэй.
- 10 Үйлчлүүлэгчээс ажлын байрныхаа дотоод орчны аюулгүй байдлыг хангах, харуул хамгаалалт тогтмол ажиллуулах, камержуулах шаардлага тавих эрхтэй. Хэрвээ үйлчлүүлэгч нь эдгээр шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд үйлчлэгч хариуцлага хүлээхгүй.
 - 4 11 “Мах импэкс” ХК-ийн Хамгаалалт аюулгүй байдлын албаны ХАБАЖ-001, ХАБАЖ-002 дагаж мөрдөнө.

5. Үйлчлүүлэгч байгууллагын эрх, үүрэг

- 5 1 Үйлчлүүлэгч байгууллагын ажилтан, тээврийн хэрэгсэл, цагаас, цагийн хооронд ажлын үнэмлэх болон тээврийн хэрэгслийн зөвшөөрөлөө шалгуулан хашаанд нэвтрэнэ.
- 5 2 Гэрээнд заасан цагаас бусад үед зайлшгүй шаардлагаар нэвтрэх бол нэгдсэн харуулын албаны даргаас зөвшөөрөл авч нэвтрэнэ.
- 5 3 Өөрийн зориулалтын зоорь агуулахад зөвхөн өөрийн байгууллагын бүтээгдэхүүнийг хадгална.
- 5 4 Ашиглалтын буруугаас шалтгаалсан цахилгаан, ус, уурын шугам сүлжээг гэмтээх, бохирдуулж битүүрүүлэхгүй байх.
- 5 5 Үйлчлэгч байгууллагаас төлбөрийн нэхэмжлэлээ гэрээний хугацаанд явуулж байхыг шаардах.
- 5 6 Ажлаас халагдсан ажилтны ажлын үнэмлэхийг хураан авч энэ тухайгаа нэгдсэн харуул хамгаалалтын албанд мэдэгдэх үүрэгтэй.
- 5 7 Өөрийн байгууллагын ажилтан, тээврийн хэрэгслийн нэвтрэх бүртгэлийг гаргаж гэрээнд хавсаргах.
- 5 8 Байгууллагын хашаанд архидан согтуурч, танхай үйлдэл гаргахгүй байх, ажилтны ёс зүй, харилцааны асуудлыг бүрэн хариуцах.
- 5 9 Үйлчлэгч байгууллагын инженер, техникийн албанаас шаардлагатай тохиолдолд мэргэжлийн туслалцаа авах, кар, погрузчик, автомашин хэрэглэх асуудлаар зөвхөн тус байгууллагын удирдлагуудад мэдэгдэн зөвшөөрөл авах.
- 5 10 Үйлчлэгч байгууллагын үзүүлж буй үйлчилгээтэй холбоотой санал өгөх, шаардлага тавих өөрийн буруугаас шалтгаалаагүй доголдол дутагдлыг засварлуулах эрхтэй.

6. Нууцыг хадгалах

- 6 1 Талууд энэхүү гэрээний дагуу олж мэдсэн мэдээлэл болон баримт бичгийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүрэгтэй.
- 6 2 Талуудын хооронд шилжүүлэн өгсөн нууцын чанартай мэдээлэл, баримт бичигтэй зөвхөн гэрээний дагуу хийж байгаа ажилтай шууд холбоо бүхий албан тушаалтан танилцана.

7. Хариуцлага

- 7.1 Үйлчлүүлэгч, үйлчлэгчийн аль аль нь энэ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.
- 7.2 Үйлчлэгч нь үйлчлүүлэгчийн бусадтай байгуулсан гэрээг бүрэн биелүүлээгүйтэй холбогдох хариуцлагыг хүлээхгүй.

8. Бусад заалт

- 8.1 Энэ гэрээний дагуу хийсэн ажлыг шаардлагатай гэж үзвэл талуудын хамтран үйлдсэн акт (протокол) болон үйлчилгээ үзүүлсэн тухай бусад баримт бичигт тусган тодорхойлно.
- 8.2 Талуудын гэрээгээр хүлээсэн үүрэг бүрэн биелсэн, харилцан хийх тооцоог зохицуулж дууссан нөхцөлд гэрээг биелж дууссанд тооцно.
- 8.3 Хэрэв энэ гэрээнд заасан болон түүнтэй холбогдох асуудлаар маргаан гарвал талууд түүнийг хэлэлцээний замаар шийдвэрлэхийн тулд бүхий л арга хэмжээг авна.
- 8.4 Хэрэв уул маргааныг хэлэлцээний замаар шийдвэрлэж чадахгүйд хүрвэл гэрээтэй холбоотой аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Үндэсний Арбитрт түүний хэрэг шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.
- 8.5 Гэрээнд талууд гарын үсэг зурмагц хүчин төгөлдөр болно.
- 8.6 Гэрээний үндсэн эхийг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.
- 8.7 Талуудын хууль ёсны хаяг

Үйлчлэгч

Хаяг _____

Утас _____

Банкны харилцах дансны

дугаар _____

Албан тушаал _____

Гарын үсэг: _____

Үйлчлүүлэгч:

Хаяг: СХЗ, 4РХЗӨН

Утас: 70171027

Банкны харилцах дансны

дугаар: _____

Албан тушаал _____

Гарын үсэг: _____